


Монголын доогуур нүх малтсан нь

Улсын хөгжил корпорацийн атганд



Rhodante Ahlers & Vincent Kiezebrink & Sukhgerel Dugersuren

Colophon

Монголын доогуур нүх малтсан нь

Улсын хөгжил корпорацийн атганд

2020 оны 2 сар

Зохиогчид: Rhodante Ahlers, Vincent

Kiezebrink, Sukhgerel Dugersuren

Бэлтгэл: Frans Schupp

Нүүр зураг: Tserenjav Demberel

Энэхүү нийтлэлийг Нидерландын Гадаад хэргийн яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр бэлтгэв. Нийтлэлийн агуулга нь зөвхөн SOMO-ийн хариуцлага бөгөөд Нидерландын ГХЯ-ны үзэл баримтлал хэрхэвч биш болно.



Oyu Tolgoi Watch

Бага тойруу, 44-204

Ulaanbaatar, 46A Mongolia

T: 976-98905828

otwatch@gmail.com

Оюу Толгойн Хяналт ТББ нь Оюу Толгой төслийн олон хүрээлэн буй орчин, хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгааг хянах зорилгоор 2009 онд байгуулагдсан. OT улсын Хяналт ТББ-ыг шударга бус хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурахыг эсэргүүцэж төрийн байгууллагуудтай идэвхтэй мэтгэлцэж ирсэн ИНБ-ууд байгуулсан. Байгуулагдсан цагаасаа хойш OT Хяналт ТББ нь үндэсний болон олон улсын иргэний нийгмийн сүлжээнүүдтэй хамтран хөгжлийн явцад хүний эрхийг хүндэтгэдэг уул уурхай, хөрөнгө оруулалтыг шаардах, хянах чиглэлээр ажиллаж байна.



Stichting Onderzoek Multinationale Ondernemingen

Үндэстэн дамнасан корпорациудыг судлах төв

**Sarphatistraat 30, 1018 GL Amsterdam
The Netherlands**

T: +31 (0)20 639 12 91

info@somo.nl

www.somo.nl

Үндэстэн дамнасан корпорациудыг судлах төв (SOMO) нь бие даасан, ашгийн бус, судалгааны сүлжээ байгууллага бөгөөд тогтвортой хөгжлийн нийгэм, байгаль орчны болон эдийн засгийн асуудлуудыг судалдаг болно. 1973 оноос хойш үндэстэн дамнасан корпорациуд, тэдгээрийн үйл ажиллагааны үр дагавар дэлхийн хүн ам, тойрон орчинд хэрхэн тусдагийг судалдаг болно.



Монголын доогуур нүх малтсан нь

Улсын хөгжил корпорацийн атганд

SOMO

Rhodante Ahlers & Vincent Kiezebrink & Sukhgerel Dugersuren

Улаанбаатар, 2020 оны 2 сар

Гарчиг

Хураангуй	3
1 Оршил	5
1.1 Оюу Толгойн алт, зэсийн уурхайн товч түүх	7
1.2 Тайлангийн зорилго, зохион байгуулалт	11
1.3 Аргачлал	12
2 Эзгүй хээр: Олборлох замаа зассан нь	13
2.1 Чөлөөт зах зээлд шилжих Монголын шилжилт	13
2.2 Монголд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах нь	16
3 Монгол ба ОТ: Хөшигний цаагуурх тулгалт	19
3.1 Хаалганд шургуулсан хөл: АНУ-ын сонирхлыг Монголд тэлэх нь	23
3.2 ОТ-н төлөөх гаднын зохион байгуулалттай лобби	25
3.3 Монгол Улсын эрх зүйн болон санхүүгийн тогтворгүй байдал ба өрнөдийн уул уурхайн ашиг сонирхол	27
3.4 Улс төрийн хонжоо юу? эсвэл Монголын хувь заяа юу?	31
4 Хэн Оюу Толгойгоос хожиж байна вэ?	34
4.1 Монгол Улсын татварын алдагдлууд	34
4.2 Оюу Толгойн гацаа	38
4.2.1 Хөрөнгө оруулагч ба улсын хоорондын маргаан таслах (ISDS) заалт	39
4.2.2 2015 оны ОТДУББСТ / Дубайн гэрээ	41
5 Дүгнэлт	43
6 Зөвлөмж	46
Ишлэл	50

Хураангуй

Энэхүү тайланд wikileaks-д ил цацагдсан АНУ-ын Элчин сайдын яамны цахилгаан мэдээг шинжлэн Оюу Толгойн өмчлөгч компаниуд Рио Тинто ба Туркойз Хилл (хуучнаар Айвенхоу Майнз) ба тэдгээрийн ардах хүчирхэг гүрнүүд хамсан Монгол Улсын Засгийн газрыг ард түмнийхээ ашиг сонирхлыг хангахгүй гэрээнд түлхэсэн байдлыг илчилнэ.

Монгол Улс нь хэт үрэлгэн урамшууллауудыг санал болгосноор төрийн санг дүүргэхгүй харин «барууны» корпорацийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн гэрээ байгуулсан. Олон улсын хүлээлтийг хангах дарамт болон хүчний тэнцвэргүй байдал зэрэгт уул уурхайд дулдуйдсан чөлөөт эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь суурь болж өгснийг харуулна. Зах зээлийг төрийн оролцооноос хамгаалах «сайн засаглал» ба «хуулийг дээдлэх» явдлыг дэмжих бодлого нь практик дээр засаглалын харилцан хяналтын тэнцвэрийг устгасан. Бусад нөлөөлсөн хүчин зүйлсэд улс төрийн тогтворгүй байдал болон Монголын улс төрийн элитийн холбирхой явдал зэрэг нь 2007-2008 санхүүгийн хямралтай хавсран хэлэлцээрт орох Монгол улсыг хүчгүйдүүлж, авилгад өртөмтгий болгосон зэрэг орно.

Монголын хамгийн том уурхай болох Оюу Толгойн алт, зэсийн уурхай нь өнгөрсөн хэдэн арван жилд Монгол Улсын улс төр ба хууль тогтоомжийг тодорхойлох төв нь байв. Эдийн засгийн гол салбар нь уул уурхай болсон Монгол Улс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, үндэсний өрийг тогтворжуулах болон нийгмийн ба байгаль орчны аюулгүй байдлыг хангах асуудлын тэнцвэрийг хадгалах гэж тэмцсээр байна.

Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ (ОТХОГ)-г 2003 оноос УИХ гишүүд, улс төрчид болон иргэний нийгмийнхэн тээнгэлзэж ирсэн. Оюу Толгойн төслийн чамлалтай үр ашиг ба зардал хэтрүүлэлтийг шалгасан УИХ-ын ажлын хэсэг нь уурхайгаас хүртэх Монголын орлогыг сайжруулахын тулд МУ-ын Засгийн газар, Рио Тинто нарын хооронд байгуулсан гэрээнүүдийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай гэж дүгнэсэн. 2019 оны 11 -р сард Монголын парламент Оюу Толгойн уурхайд холбогдох бүх гэрээг Монголын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулахыг үүрэгдсэн тогтоолыг санал нэгтгэйгээр баталсан.

Дэлхийн банкны 2003 оны Олборлох салбарын тойм тайланд засгийн газраас компаниудтай байгуулах гэрээнүүдэд байгаль орчин ба нийгмийн чиглэлээр ирээдүйдээ хийх зохицуулалтыг хязгаарласан байдаг тул байгалийн баялаг нь шууд тогтвортой хөгжил болж хувирах нь хүндрэлтэй тухай нарийвчлан тодорхойлсон атал зөвлөмжөөс сургамж аваагүй байгааг энэхүү тайландаа толилуулна. Олон улсын хөрөнгө оруулалт ба татварын гэрээгээр дэмжигдсэн Оюу Толгой төслийн гэрээний санхүүгийн тогтворжуулалт ба арбитрын заалтууд нь 2015 оны хэт том тул унах магадлалгүй санхүүжилтийн зээлийн багц, барууны орнуудын улс төр болон санхүүгийн дэм бүхий хүндийн жингээр улам баталгаажиж Монгол Улсын бодлогын замыг гуйвуулжээ.

Баялгийн нөөцийн мэдлийг ардчилахад чиглэсэн дараах зөвлөмжийг толилуулж байна.

Үүнд:

- ▣ Гэрээнүүдийг эргэн хэлэлцэж Монголын ард түмэнд илүү ашиг өгөөжтэй болгохыг баталгаажуулах,
- ▣ Нийтийн эрх ашгийн төлөөх эрх зүйг хамгаалахын тулд Хоёр талын хөрөнгө оруулалтыг дэмжих гэрээнүүдийг эргэн хэлэлцэх,
- ▣ Монголын нүүдэлч ахуй соёл болон өвөрмөц экологийг чухалчлах,
- ▣ Бүх дипломат албад ба олборлох салбарт оролцоо бүхий санхүүгийн байгууллагууд Олборлох үйлдвэрлэлийн тойм тайлан (ЕШ)-гийн зөвлөмжүүдийг, ялангуяа эдийн засгийн төрөлжүүлэлт, нутгийн хүн амын оролцоо ба ашиг хуваарилалтад холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэх,
- ▣ Олныг хохироон цөөнхийн өсөлтийг хангах бодлогоос татгалзаж үндэсний болон олон улсын эдийн засгийн ашиг сонирхлыг тогтвортой хөгжлийн зорилгууд болон 2015 оны Парисын уур амьсгалын хэлэлцээрт нийцүүлэх.

Монголчуудад өөрийн баялгийг ашиглах, түүнд эзэн суухын тулд үндэстэн дамнасан талуудын дэлхийд хууль ёсны хэмээн ойлгуулсан баялгийн дээрэм зогсоох шаардлагатай. Энэ нь бид «сайн засаглал» ба «хуулийг дээдлэх» гэх ойлголтуудыг корпорацийн сонирхол ба ашиг олзлох горимоос холдуулж эрүүл газар дэлхий ба түүний нийт хүн амд чиглүүлэн шинэчлэн тодорхойлох хэрэгтэй.

1 Оршил

[2004 онд] «Канадын хайгуулын Айвэнхоу майнз компани [Оюу Толгойн] ашиглалтын лицензи эзэмшиж байв[.] Айвэнхоугийн хуулийн ерөнхий зөвлөх Жон Фонинийн хэлсэнчлэн, Монголын удирдлагууд туйлын нааштай хандаж, бүр өөрийн санаачлагаар гэрээг байгуулна гэж «амлаж» байсан аж. Парламент эсхүл олон нийттэй зөвлөлдөх аливаа хуулийн зохицуулалтыг үл харгалзан гэрээг ерөнхий сайд бие даан байгуулж Монголд тулгах эрхтэй мэтээр МАХН-ын дээд удирдлагууд үзэж байв. Энхбаярыг тойрон хүрээлсэн социализмын дараах үеийн хэдэн эрх мэдэлтэн дуртай зүйлээ хийж чадна гэж бизнес орчныхон ойлгож зөвхөн тэдэнтэй харьцах нь зүйтэй гэж боддог байсныг Фонини тайлбарлав. Гэвч, 1990-ээд оны дундаас ардчилал бодитой тогтож, эрх мэдлийг сонгууль болон Үндсэн хуулиар Парламент эдэлж эхэлсэн Монгол улсад социализмын үеийн эрх мэдэлтнүүдийн олон нийт болон Парламентынхаа хоолойд дурын зүйлээ чихэх чадал мөхөсдөж эхэлсэн аж. [...]

АНУ-ын ЭСЯ-ны 2009 дипломат цахилгаан мэдээ, Улаанбаатар, Монгол улс¹

Монголын хамгийн том уул уурхайн төсөл болох Оюу Толгойн алт, зэсийн уурхай нь өнгөрсөн хэдэн арван жилийн хугацаанд улс орны улс төр, хууль тогтоомжийг тодорхойлж иржээ. ОУВС-гийн тооцоогоор, Оюу Толгой нь Монгол улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүчин бөгөөд 2021 он гэхэд Оюу Толгойн зэс, алтны үйлдвэрлэл нь Монгол Улсын ДНБ-ий гуравны нэгийг бүрдүүлнэ гэжээ.² Дээрх тооцоо нь уг уурхайн ашиглалтын гэрээг хэлэлцэх нөхцөл байдал, уур амьсгал ямар байсныг илтгэнэ.

2003 онд эхэлж 2009 онд байгуулдсан Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ (ОТХОГ)-ний яриа хэлэлцээ нь энэхүү тайлангийн сэдэв болно. ОТ-н гэрээнд ардчилсан сонгуулиар сонгогдсон Засгийн газар гарын үсэг зурж байгуулсан тул хууль ёсных гэж хамгаалдаг боловч энэ үндэслэл нь Засгийн газрыг гарцаагүй байдалд оруулсан улс төрийн нөхцлийг үл харгалздаг. Гэрээнд гарын үсэг зурсан Засгийн газар нь Монголын байгалийн баялгийг тойрсон улс төрийн³ маргааны улмаас 5 хүний амь эрсдэж, 300 гаруй хүн шархдаж, 700 хүн баривчлагдаж⁴ 4 хоногийн онц байдлыг дагуулсан 2008 оны сонгуулийн дүнг эсэргүүцсэн үймээний дараа байгуулагдсан нэгэн. 2008 оны эцэс гэхэд Монголын эдийн засаг дэлхийн санхүүгийн хямралд өвдөг сөхөрсөн байсан. Оюу Толгойн гэрээг 2009 онд байгуулснаас хойш парламентын гишүүд, улс төрчид, иргэний нийгмийнхний эргэлзээ тасрахгүй ирсэн бөгөөд 2019 онд парламентын ажлын хэсэг

-
- 1 WikiLeaks, Монголын уул уурхайн мэтгэлцээн Ерөнхийлөгчийн эрх мэдлийг сулруулж байна, 2009-03-30, https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR87_a.html (2019-04-26).
 - 2 ОУВС, 2009, <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2009/cr09311.pdf> (11December 2017, Уул уурхайн технологи 2017, <https://www.mining-technology.com/features/featuresearching-for-another-oyu-tolgoi-mongolias-big-mining-expansion-5805870/> (2018-12-07).
 - 3 Булаг, У. Э. 2009, Мядар, О. Ба С. Жэксон, 2019.
 - 4 Amnesty International, <https://www.amnesty.org.uk/press-releases/mongolia-call-restraint-after-violent-protests>, Браниган, Таня, (2019-04-18).

ОТХОГ-г монголын ард түмний сонирхолд нийцүүлж, 2015 онд байгуулсан хоёр дахь Дубайн гэрээг бүхэлд нь хүчингүй болгох⁵ ёстой гэж үзэв.

2019 оны 11-р сард Захиргааны хэргийн шүүх 2015 оны гэрээ нь процессийн зөрчилтэй⁶ гэж үзэж мөн энэ сард Монголын парламент ОТ-д хамаарах бүх гэрээг эргэн хянаж Монголын ард түмний ашиг сонирхолд нийцүүлэх тухай тогтоолыг санал нэгтгэйгээр батлав⁷.

Экспортын 90 хувийг бүрдүүлэх уул уурхайн орлогоос ихээхэн хамааралтай Монгол улсын хувьд (ОУВС 2017: 16), ОТ уурхайн ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй. Малтмал түлшнээс татгалзах эрчим хүчний шилжилтэд чухал үүрэг гүйцэтгэх зэсийн эрэлт дэлхийд өсч байгаа тул 60-120 жил ашиглагдах нөөцтэй (USAID 2011: 11) Оюу Толгойн ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Оюу Толгойн зэсийн баяжмалыг Хятад руу гаргадаг. Уурхайн олон тэрбум долларын төслийн хөрөнгө оруулалтын багцад нь уул уурхайн түүхэн дэх хамгийн том төрийн санхүүжилтийн гэрээ багтдаг. Энэ мега-төсөл нь олборлолтоос гадна их хэмжээний газрын гүнийн ажил, нисэх онгоцны буудал, 70 км усны хоолой, хатуу хучилттай зам, Хятадын хил хүртэлх цахилгаан шугам зэргийг хамардаг. Удалгүй Таван толгойн нүүрсний уурхайн ойролцоо баригдах цахилгаан станцаас эрчим хүчээ авах төлөвтэй.

Усны хомсдолтой газар асар их хэмжээний усны хэрэглээтэй энэ үйлдвэрлэлд шаардагдах усыг гүнийн усны нөөцөөс татдаг юм. Ил уурхайн олборлолтын улмаас Ундайн голын гольдролыг өөрчилсөн нь орчмын нутгийн ус, бэлчээрийн нөөцөд нөлөөлсөөр байна. Уурхайн нөлөөллийн бүсэд нэн ховордсон 2 зүйлийн амьтан бүхий тусгай хамгаалалттай газар нутаг орно.⁸ Дэд бүтэц барьж байгуулах, уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа, мөн үүнийг дагасан ажиллах хүчний урсгал Өмнийн говийн эмзэг эко системд, нийгэмд болон байгаль орчинд асар их сөрөг нөлөө үзүүлж байна.⁹ Нутгийн малчид 2012, 2013 онд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Нийцэл, зөвлөгөө ба эрхийн хамгаалагч (НЗЭХ)-ийн албанд уламжлалт соёл иргэншил, амьжиргаанд гарч буй сөрөг нөлөөний талаар гомдлоо амжилттай гаргажээ.¹⁰ Олон жилийн хэлцлийн эцэст малчид, сумын засаг захиргаа болон ОТ хооронд Малчдын гомдлыг барагдуулах гэрээ байгуулсан. Малчдын гомдлыг барагдуулах гэрээг 2017 онд байгуулсныг үндэслэн НЗЭХ-ийн алба гомдолд зүүчлэх шатны ажлыг хаасан. 2019 оны 3-р сард Малчдын гомдлын барагдуулах гэрээг тохирсон ёсоор хэрэгжүүлэх ОТ-н дээд хэмжээний амлалтад үндэслэн хэрэгжилтийг хянах мониторингийн шатыг мөн хаасан болно.¹¹

5 Даваашарав, М, 2019-04 сар, <https://www.reuters.com/article/mining-mongolia-oyutolgoi-idUSL8N21M4EV>.

6 <https://theubposts.com/has-the-oyu-tolgoi-s-dubai-deal-been-voided/> (2019-12-21).

7 Hume N., 2019 11 сар <https://www.ft.com/content/e55cc25a-0c62-11ea-b2d6-9bf4d1957a67>, мөн <https://lehmanlaw.mn/newsletter/parliament-calls-for-revisit-of-key-oyu-tolgoi-agreements/> (2019-12-21).

8 Tricario, A & R. Regine, 2017, Blessed are the last for they shall be first! Re:Common, https://www.bothends.org/uploaded_files/document/Mongolia-biodiversity_offsetting_april_2017.pdf, (April 08, 2019).

9 Jackson, S.L. 2018, Meesters, M.E. & J.H Behagel, 2017.

10 CAO, 2013, http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=196, (December, 07, 2017).

11 Accountabilitycounsel, 2019, <https://www.accountabilitycounsel.org/2019/02/a-long-road-to-remedy/> and <https://www.accountabilitycounsel.org/client-case/mongolia-south-gobi-mining/#case-story> (April, 08).

Уул уурхай нь гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-аас ихээхэн хамааралтай Монгол улсын эдийн засгийн үндсэн чиглэл юм. Өнөөгийн Засгийн газар ГШХО-г татах, улсын гадаад өрийг тогтворжуулах, нийгмийн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах зэрэг зорилтуудын тэнцвэрийг олох хэцүү сорилттой тулгарч байна. МУ-ын ҮСХ-ын мэдээллээс¹² харахад ядуурлын дундаж хэмжээ 2016 оны 29,6 хувиас 2018¹³ онд 28.4 хувь хүртэл буурчээ. Эдийн засгаа төрөлжүүлээгүйн улмаас түүхий эдээс хамгийн их хамааралтай дэлхийн улсуудын нэг болчихсон Монгол нь түүхий эдийн зах зээлийн үнийн өсөлт, уналтад байнга өртөж байна.¹⁴ Иймд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (ТХҮБ) 2030¹⁵ нь эдийн засгаа төрөлжүүлж¹⁶, өсөлт- уналтын циклээс ангижрах эрмэлзлийг харуулж байна. Гэвч хорин жилийн турш олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ)-ын зааварчилгаагаар гадаадын өндөр хөрөнгө оруулалтыг шаардсан уул уурхайд дулдуйдасны үр дагаварт Монгол улс бэртэхийн хэмжээний өрөнд баригдсан, төсвийн хэт алдагдалд орсон байдалтай байна¹⁷. Өрийн эргэн төлөлт, үйлчилгээ Монгол улсын 2018 оны төсвийн гуравны¹⁸ нэгийг эзэлж байгааг харвал засаг төр нь уурхайн компаниудын шаардлагад чих зөөлөнтэй байдаг гайхах зүйлгүй юм.¹⁹ Хэдий тийм ч энэхүү нөхцөл байдал нь Монголын хөгжлийн чиг хандлага болон ард түмний сайн сайхан байдлыг хангах бодлогод корпорациудын үзүүлэх нөлөөний цар хүрээ нь болгоомжлол төрүүлхүйц байна.

1.1 Оюу Толгойн алт, зэсийн уурхайн товч түүх

Оюу Толгойн уурхайн шинэ түүх 1996 онд BHP Minerals International Exploration Inc нь Өмнөговийн цөлд зэс, алтны хайгуул хийх лиценз авч, Оюу Толгойн порфирийн зэсийн ордыг нээснээс эхэлсэн юм.²⁰ BHP-ийн лицензийн 98%-ийг авсныхаа дараа Айвенхоу Майнз нь 2001 онд өндөр агуулгатай зэс, алтны ордуудын хэмжээ, нөөцийг баталгаажуулжээ. Тээнгэлзсэн Монголд тал засахын тулд Айвенхоу Майнз 2003 оны

12 ҮСХ, 2018 статистикийн эмхэтгэл <http://www.en.nso.mn/>.

13 НҮБ-ын тоо баримтаас харахад Монгол улсын ядуурлын дундаж хэмжээ 2014 оны 21% -иас 2018 онд 29.6% хүртэл өссөн байна. Trankmann, B. 2018, UNDP, <http://www.undp.org/content/undp/en/home/blog/2018/Nomads-no-more.html>, and UNDP, 2019, Mongolia: Human Development report 2019, http://hdr.undp.org/sites/all/themes/hdr_theme/country-notes/MNG.pdf, and ADB, 2019, Poverty In Mongolia, <https://www.adb.org/countries/mongolia/poverty> (21 November 2018).

14 Li, Gupta, and Yu, 2015, and Hatcher, P. 2016a. For detailed data see: Global finance at <https://www.gfmag.com/global-data/economic-data/countries-highest-gdp-growth> and International Monetary Fund country data at <http://www.imf.org/en/Countries/MNG#countrydata> (9 December 2018).

15 GoM, 2016, Mongolia Sustainable Development Vision 2030, http://www.un-page.org/files/public/20160205_mongolia_sdv_2030.pdf and UNEP, 2018, http://unepinquiry.org/wp-content/uploads/2018/11/National_Sustainable_Finance_Roadmap_of_Mongolia.pdf, accessed December 17, 2018.

16 Нэмэлт мэдээллийг J. Lander, 2014.

17 Jubilee debt, 2017, <https://jubileedebt.org.uk/countries/mongolia> and Jubilee debt, 2019 <https://jubileedebt.org.uk/press-release/crisis-deepens-as-global-south-debt-payments-increase-by-85> (April 18, 2019).

18 UNEP, 2018, http://unepinquiry.org/wp-content/uploads/2018/11/National_Sustainable_Finance_Roadmap_of_Mongolia.pdf. Page 46 (December 17, 2018).

19 Davaasharav, M & B. Lewis, May, 22, 2018, <https://www.reuters.com/article/us-riotinto-mongolia/rio-tinto-presses-mongolia-to-shore-up-copper-investment-idUSKCN1IN18K>, (August 6, 2018).

20 Wu, J.C.1999, <https://s3-us-west-2.amazonaws.com/prd-wret/assets/palladium/production/mineral-pubs/country/1999/9319099.pdf> (6 December 2018).

сүүлчээр Засгийн газарт 50 сая долларын зээлийг (зөвлөлтийн үед ОХУ-д тавьсан өрийг төлөх) зорилгоор олгосон байдаг²¹. Хөрөнгө хайсан Айвенхоу Майнз Рио Тинтотой 2006 онд стратегийн түншлэлийн гэрээ байгуулж улмаар Рио Тинто²² нь 2011 онд Оюу Толгойн уурхайн дийлэнх эзэмшил, үйл ажиллагааг өөрийн мэдэлд авав. Оюу Толгойн ордын бас нэг хамааралтай этгээд бол Канадын Entree Resources компани бөгөөд энэ нь 2004 онд Оюу Толгой ХХК-ийн далд ордын нэлээд хэсгийн хамтран эзэмшигч болсны зэрэгцээ одоогийн Оюу Толгойн ил болон далд уурхайг тойрсон талбайд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.²³

2019 оны байдлаар Оюу Толгойн уурхайг гурван үндсэн гэрээгээр зохицуулж байна:

- ▣ 2009 онд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ (ОТХОГ);
- ▣ 2011 онд байгуулсан Нэмэлт, өөрчлөлт бүхий Хувь нийлүүлэгчдийн гэрээ (НӨХНГ);
- ▣ 2015 оны Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (ОТДУББСТ).

Эдгээр гурван хэлэлцээрийн²⁴ тус бүр нь Дэлхийн банкны эрх зүйн өөрчлөлтийг дэмжих техник туслалцааны хөтөлбөрүүдийн дагуу хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулах, бодлогын болзошгүй өөрчлөлтөөс хамгаалан тогтворжуулах, хөрөнгө оруулагчдын ашиг орлогыг баталгаажуулахыг хангасан байдаг²⁵. Дэлхийн банкны өөрийн томъёолсноор:

«Банк нь 10 гаруй жилийн туршид хувийн хэвшилд тулгуурласан уул уурхайн салбарын хайгуул, бүтээн байгуулалтын эрх зүйн тогтолцоог боловсруулах ажлыг бөөцийлэн дэмжиж ирэв. Энэ хугацаанд гол чиглэл нь уул уурхайд хэрэглэхэрхгүй, санхүүгийн дэглэмийг тогтооход оршив.»²⁶

Таван толгойн эрчим хүчний гэрээ бол мега-төслийн дөрөв дэх томоохон гэрээ юм. Оюу Толгой ордыг цахилгаан эрчим хүчээр хангах нь Оюу Толгойн хөгжлийн ба хэлцлийн чухал хэсэг угтаа байсан боловч уг асуудлыг Тавантолгойн хэлэлцээрийн хүрээнд 2018 оны 12-р сарын 31-ний өдөр л гэрээ байгуулж шийдсэн түүхтэй. Тохиролцоо цаашид хэрхэн өрнөх нь энэ илтгэлийн сэдвээс хальсан асуудал юм.

Өнөөдөр Оюу Толгой компанийн 66 хувийг Канадын Туркойз Хилл Ресурс (TRQ), 34 хувийг Монголын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК компани эзэмшиж байна. Харин Туркойз Хилл Ресурсын дийлэнх хувийн өмчлөгч Рио Тинто нь Оюу Толгойн уурхайн ажиллагааг хариуцаж байна.

21 Айванхоу Майнз 2004-08-17, МУ-ын ерөнхийлөгчийн Оюу Толгойн төслийн хөгжлийг дэмжих мэдэгдлийг талархан хүлээж авлаа, https://www.turquoisehill.com/site/assets/files/4639/2004-08-17_nr.pdf, accessed 2018-12-06.

22 Рио Тинто нь түншлэлээ Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан эсэхээс үл хамааран тогтоож байна, 2007, https://wikileaks.org/plusd/cables/07ULAAANBAATAR119_a.html#help_2 (18.4.2019).

23 Entree Resources website, <https://www.entreeresourcesltd.com/corporate/about-us/> (18.4.2019).

24 Бидний Уул уурхайн татварууд (2018), өмнөх тайланд 2009 оны ХОГ ба 2011 оны нэмэлт өөрчлөлт, Хувь нийлүүлэгчдийн гэрээний талаар тодорхой мэдээлсэн болно <https://www.somo.nl/nl/mining-taxes/>, we provided a detailed description of the 2009 Investment.

25 Hatcher, P.2012 on Mongolia and Hatcher, P. 2014 on Asia.

26 Дэлхийн банк, 2009, «Төслийн мэдээллийн бичиг баримт» cited in Hatcher, P. 2016b:185.

Монголд Рио Тинтотой хэзээ ч уйтгарлах мөч тохиолдохгүй

Монгол Улсын Засгийн газар (МУЗГ), Рио Тинтогийн хоорондын харилцаа бусгаа болохыг өнгөрсөн хоёр жил ил харууллаа. 2018 оны 1 дүгээр сард, Туркойз Хилл Ресурс (TRQ)-т Монгол Улсын Засгийн газраас 155 сая долларын татварын нэхэмжлэл тавьж цочирдуулсан бол дараахан нь SOMO-ийн Уул уурхайн татвар хэмээх тайланд TRQ-ийн татвараас зайлсхийх тогтолцоог илчлэн нийтэд танилцуулав. 2 дугаар сарын 1-нд TRQ-ийн хоёр дахь том хувьцаа (11%) эзэмшигч SailingStone Capital-аас Рио Тинто TRQ-ийн менежментийн хараат бус байдалд нөлөөлсөн хэмээн компанийн засаглалыг илүү ил тод болгохыг шаардсан захидал хүргүүлэв. Асуудлыг МУ-ын Татварын албатай шийдвэрлэх боломжгүйд хүрсэн тул TRQ нь Лондонгийн Олон улсын арбитрын шүүхэд маргаан үүсгэж болзошгүйгээ мэдэгдэв.²⁷ 3 дугаар сарын 15-ны өдөр «Оюу Толгой» ХХК нь «маргаан үүсгэх мэдэгдэл» гэх нэртэй зүйлийг Засгийн газарт, дараа нь 2018 оны 4-р сарын 13-ны өдөр Монгол Улсын Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл хүргүүлсэн боловч шүүх уг хэргийг түдгэлзүүлэв.

Үүний зэрэгцээ, 3-р сард Монголын Авлигатай тэмцэх газар «Оюу Толгой» ХХК-д мэдээлэл авах хүсэлт гаргав. Долоо хоногийн дараа Швейцарийн холбооны шүүхийн шийдвэрээр 2009 онд Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсантай холбоотой байж болзошгүй авлигын хэргийг мөрдөн шалгах хүрээнд Монголын Сангийн сайд асан Сангажавын Баярцогтын Швейцарийн банк дахь дансуудыг хураасан нь хууль ёсны үйлдэл болохыг баталгаажуулжээ.²⁸ 4-р сарын эхээр С.Баярцогтыг, дараа нь мөн хоёр ерөнхий сайдыг 2009 оны Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, 2015 оны ОТ-н далд уурхайн хөгжил, санхүүжүлтийн төлөвлөгөөг байгуулахад албан тушаалаа урвуулан ашигласан байж болзошгүй үндэслэлээр Авлигатай тэмцэх газраас баривчлав.²⁹ С.Баярцогтыг 6-р сард шоронгоос сулласан боловч 2019 оны 1-р сард дахин хорьж, санхүүгийн барьцаа төлсний дараа батлан даалтад гаргав.³⁰

- 27 Sanderson, Cosmo, 2018, <https://globalarbitrationreview.com/article/1166728/mongolia-risks-licia-claim-over-mining-tax-bill>, and TRQ website, <https://www.turquoisehill.com/site/assets/files/3655/tur-nr-15-03-2018.pdf> (07 december 2018).
- 28 SWI, March 19, 2018, https://www.swissinfo.ch/eng/business/mining-and-corruption_swiss-court-upholds-asset-seizure-in-case-of-mongolian-ex-minister/43983526, and S&P Global, March 19, 2018, <https://www.spglobal.com/marketintelligence/en/news-insights/trending/dygtvgsqwzrakmhmzn4lmq2>, and Miller, J. & T. Edwards, march 21, 2019, <https://www.reuters.com/article/us-rio-tinto-oyu-tolgoi/swiss-probe-rio-tinto-over-possible-bribes-ex-mongolian-minister-expects-to-be-cleared-idUSKBN1GX2WL> (07 december 2018).
- 29 Turquoise Hill Resources website, <https://www.turquoisehill.com/site/assets/files/3726/nr-march-13-2018.pdf>, Jamasmie, C. March 13, 2018, <https://www.mining.com/anti-corruption-body-asks-rio-oyu-tolgoi-related-info/>, and Jamasmie, C. May 22, 2018, <http://www.mining.com/rio-tinto-says-investors-take-stance-oyu-tolgoi-test-case/> (18 april 2019).
- 30 Davaasharav, M & B. Lewis, jan. 29, 2019, <https://www.reuters.com/article/us-mining-riotinto-mongolia/mongolia-overseas-investigators-probe-oyu-tolgoi-corruption-claims-as-ex-minister-re-arrested-idUSKCN1PN0OY> (18 april 2019).

Уг тайланг бичих үе (2020 оны 1 сар)-ийн байдлаар Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнүүдтэй холбоотой авилгын хэргийн мөрдөн байцаалт үргэлжилсээр байна.

2018 оны 4-р сард Лондонд болсон Рио Тинто компанийн жилийн тайлангийн хурал дээр Рио Тинтогийн дарга болон гүйцэтгэх захирал хоёулаа Оюу Толгойн уурхай нь Монголын ард түмэн болон Рио Тинтогийн хувьцаа эзэмшигчдэд ихээхэн өгөөжтэйг итгүүлэх гэж нэлээд чармайв. Тавдугаар сард TRQ нь гүйцэтгэх захирлаа гэнэт чөлөөнд гарган долдугаар сард шинэ гүйцэтгэх захирлаар Ульф Келлманыг ажилд авав. Кэллман нь Рио Тинто-оос угшилтай бөгөөд Оюу Толгойн хоёр дахь шатны барилгын ажлыг санхүүжүүлэх 4, 4 тэрбум ам.долларыг босгох ажилд маш идэвхтэй оролцсон нэгэн.³¹

10-р сард TRQ нь «хөрсний хүнд нөхцөл байдал» -аас болж гүний уурхайн үйлдвэрлэл эхлэхийг 2021 оны 1 улиралаас бүр 3 улирал хүртэл дахин хойшлуулсныг мэдэгдэв. 2018 оны сүүлийн долоо хоногт ЗГ, Оюу Толгой ХХК нь Тавантолгойн нүүрсээр ажиллах цахилгаан станц барьж Оюу Толгойн уурхайг дотоодын эрчим хүчээр хангах зорилготой Эрчим хүчний эх үүсвэрийн суурь гэрээ (ЭХЭҮЦГ)-нд гарын үсэг зурав. Харьцангуй ойр байршилтай уг станц нь ОТ ХХК-ийн эзэмшилд байх бөгөөд БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний хамаарлаас ангижуулах учиртай юм. Санхүүжилтийг төрийн өмчит «Эрдэнэс Тавантолгой» -н 30 хувийг төлөвлөсөн ёсоор 2019 оноос эхлэн хөрөнгийн биржээр нийтэд арилжаалан 3 тэрбум ам.доллар³² босгож хийхээр тохиров.

Гэтэл Рио Тинто 2019 оны 7-р сард зарласнаар Оюу Толгойн далд уурхайн барилгын ажил 16-аас 30 сараар хойшлогдож байгаа нь ОТ-н хувийн болон төрийн өмчлөгч нарт 1.9 тэрбум ам. долларын нэмэлт зардал болж тусах аж.³³

Оюу Толгой төслийн хүлээлтийг хангаагүй, зардал хэтрүүлсэн ажиллагааг шалгасан Монголын парламентын ажлын хэсэг нь Монгол улсад тусах өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд Рио Тинто болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан Оюу Толгойн гэрээнүүдэд өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж дүгнэв.³⁴

31 Hume, N. 2018-07-31, TRQ-ийн шинэ захирлыг хувь нийлүүлэгчид болгомжлолтой хүлээн авав <https://www.ft.com/content/72dedf86-94d8-11e8-b67b-b8205561c3fe> (18 april 2019).

32 Ker P Nov 2018 <https://www.afr.com/companies/mining/mongolia-wants-rio-to-work-with-tavan-tolgoi-20181031-h17cdm> (2020-01-21).

33 Hume, N. 2019-07-16, Монгол дахь эзсийн уурхайн хойшуулалт ба өртгийн үсрэлтийн тухай сонордуулга гаргав <https://www.ft.com/content/a69d8a48-a751-11e9-984c-fac8325aaa04> (7 September, 2019).

34 Stanway D. et al, July 19, 2019, <https://www.reuters.com/article/us-mongolia-oyutolgoi/rio-tinto-under-fire-as-mongolia-presses-for-mine-deal-changes-idUSKCN1UE1P1> (7 September, 2019).

Улмаар, 2015 оны далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг Монгол Улсын парламент батлаагүй тул хуулийн хүчингүй гэж үзжээ.³⁵ 2018 оны 11 дүгээр сард Захиргааны хэргийн шүүх 2015 оны Дубайн гэрээг зохих журмын дагуу хийгдээгүй гэж шийдсэн боловч өмнө нь байгуулсан гэрээнүүдэд суусан арбитрын заалтууд нь ОТ-н гэрээний асуудлаар дээрх шийдвэрийн дагуу зохих арга хэмжээг авахад хүндрэл учруулна. Парламент нь ОТХОГ-г МУ-ын хууль тогтоомж, монголын ард түмний ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулах шийдвэрийг санал нэгтэй батлав.³⁶

1.2 Тайлангийн зорилго, зохион байгуулалт

Энэхүү тайлангийн анхаарлын төвд Оюу Толгойн ажиллагааг зохицуулж буй тохиролцоонууд бөгөөд үүний хамгийн чухал нь 2009 оны ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээ (ОТХОГ) юм. Энэхүү тайлан нь уг гэрээнд хүргэсэн яриа хэлэлцээний үйл явцын талаар нарийн мэдээлэл өгөх, мөн Оюу Толгой компанийн эзэмшигч корпорациуд, тэдгээрийг дэмжигч хүчирхэг улс орнууд Монгол Улсын Засгийн газрыг ард түмнийхээ эрх ашгийг хангах чадахгүй гэрээнд хэрхэн түлхэж оруулсныг харуулах зорилготой юм.

2-р бүлэгт Олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ)-ууд уул уурхай ард түмэнд хортой тусдаг тухай өргөн тархсан эрдэм шинжилгээний дүгнэлтүүдийг үл таниулан Монгол Улсыг уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн хөгжилд хэрхэн түлхсэн байдлыг шинжинэ. Дараагийн бүлэгт олон улсын зохион байгуулалттай дипломат шахалт бүхий кампанит ажлын үр дүнд Оюу Толгойн хэлэлцээг Рио Тинто болон корпорацийн түншүүдэд ашигтай байдлаар эргүүлснийг харуулав. АНУ-ын Монгол улс дахь ЭСЯ-ны дипломат телеграммын агуулгад түшиглэн барууны дипломат ертөнцийн гайхамшигтай жишгийг илчилж, корпорацийн ашиг сонирхолд дипломат хүч хэрхэн үйлчилдгийг харуулав. 4-р бүлэгт Оюу Толгойн ийнхүү гажууд хэлэлцээний үр дүнд үүссэн тохиролцоо нь Монгол Улсын хувьд чамлалттай үр өгөөж өгч, гэрээнд тохиролцсон арбитрын заалтууд нь Оюутолгойг зохицуулах аливаа гэрээнд өөрчлөлт оруулах Монгол Улсын боломжийг хааж, улмаар тус улсын нийтийн сонирхолд нийцсэн хууль тогтоох бүрэн эрхийг хязгаарлаж байгааг харуулав. Тайлан илтгэлийн төгсгөлд үндсэн олдворуудыг хураангуйлж, тэдгээрийн дүн шинжилгээнд тулгуурласан зөвлөмжүүдээр дуусгавар болгоно.

35 Cision website, <https://www.prnewswire.com/news-releases/turquoise-hill-notes-administrative-court-proceedings-in-mongolia-300960721.html> (11 december 2019).

36 <https://lehmanlaw.mn/newsletter/parliament-calls-for-revisit-of-key-oyu-tolgoi-agreements/>, Hume, N, November 21, 2019, <https://www.ft.com/content/e55cc25a-0c62-11ea-b2d6-9bf4d1957a67> (21 December, 2019).

1.3 Аргачлал

Энэхүү тайлан нь SOMO болон Оюу Толгойн Хяналт ТББ-ын уул уурхайн нийгэм, эдийн засгийн шударга бус явдлыг илчлэх хүрээнд Оюу Толгой төслийн хэрэгжилттэй холбоотой гарсан сөрөг нөлөөлтэй тэмцэх ажлын нэг хэсэг юм. Энэхүү тайлан нь Оюу Толгойн ашгийн татвараас хэрхэн зайлсхийсэн, мөн Рио Тинто, Монгол Улсын Засгийн газрыг хөрөнгө оруулалтын тэгш бус гэрээнд хэрхэн түлхэж оруулсныг тусгасан *Уул уурхайн татварууд 2018 оны тайлан илтгэлийн үргэлжлэл* юм.

Судалгаанд эрдэм шинжилгээний бүтээл, хэвлэл мэдээллийн нийтлэл, Reuters Eikon, Orbis зэргийн корпорациудын мэдээллийн сан, Оюу Толгой ба түүний эзэмшигчдийн санхүүгийн ба жилийн тайлан, OpenOil зэрэг хараат бус шинжээчдийн мэдээллийг ашигласан болно. МУ-ын төрийн албан хаагч нартай хийсэн ярилцлагаар олсон мэдээллийг тайлан илтгэлийн ерөнхий өнгө аяс болгон ашигласан ба эх сурвалж болгон ашигласныг ярилцагчийн хүсэлтээр нэр заахгүй тусгасан. Энэхүү илтгэлд анх 2011 онд Wikileaks-т цацагдсан Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-ны дипломат цахим шуудангийн агуулгыг дэлгэлээ³⁷.

Судалгааны агуулгыг МУ-ын улс төр-эдийн засаг ба баялгийн удирдлага, ОУСБ-ууд ба Монголын эрх зүйн тогтолцоо, мөн Хөрөнгө оруулалтын гэрээний суурь санхүүгийн загварын зэрэг дөрвөн мэргэжлийн экспертээр хянуулсан. Цаг зав, идэвх санаачилга гарган тайланг гяргай шинжиж үнэтэй шүүмж өгсөнд бид талархаж байна. SOMO-ийн чанарын баталгааны дотоод журмаар судлагдсан талуудыг судалгааны үр дүнд хариу өгөх боломжоор хангасны дараа тайланг нийтлэдэг болно. Бид Рио Тинто ба Туркойз Хил Ресурсын арвин хариултуудын зүй бус гэсэн заримыг тайлангийн холбогдох хэсэгт оруулсан болно. Рио Тинто ба Туркойз Хил Ресурсын ирүүлсэн хариуг бүрэн эхээр нь SOMO-ийн вебсайтаас харж болно.

37 Wikileaks Website, <https://wikileaks.org/> (8 April 2019).

2 Эзгүй хээр: Олборлох замаа зассан нь

2.1 Чөлөөт зах зээлд шилжих Монголын шилжилт

Монгол Улс 1990 онд тусгаар тогтнолоо дахин сэргээж, Орос, Хятад зэрэг улсуудтай эвсэлдэхгүй, харин хөршүүдтэйгээ тэнцвэртэй харилцаа тогтоохыг эрэлхийлжээ (Ривз 2011). ЗХУ-аас олдохгүй болсон хэрэгцээт санхүүгийн хөрөнгийг орлуулахын тулд Монгол Улс Олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ), ялангуяа Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банк (ДБ), Азийн хөгжлийн банк (АХБ)-нд хандаж, тэдгээр нь төрийн удирдлагат эдийн засгийг «чөлөөт зах зээл»-д шилжүүлэх неолиберал реформын багцыг хэрэгжүүлэхээр оруулж ирэв.³⁸ 1997 онд ашигт малтмалын тухай, 1993, 2002 оны гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсруулах ДБ, АХБ-ны техникийн туслалцаанд уул уурхай тод томруун тусгагдаж байжээ.³⁹

1991 оноос хэрэгжүүлсэн Бүтцийн өөрчлөлтийн бодлогын ээлж дараатай зээлийн багцууд нь бүс чангалах гүн гүнзгий арга хэмжээ авах орчин бүрдүүлж, төрийн өмчийг хувьчлах, төрийн секторын төвлөрлийг сааруулах замаар улсын нөөц хөрөнгөд тавих нийтийн хяналтыг бууруулж ирэв. 1995 он гэхэд Монголын мал аж ахуй, худалдаа ба үйлчилгээний салбарын улсын өмчийн 95%-ийг хувьчилсан байв⁴⁰. Цаашлаад уул уурхайг Монголын эдийн засгийн орлогын гол эх үүсвэр болгох боломжийг бүрэн ашиглах зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих институцийн тогтолцоог бий болгосон. Уул уурхайн салбарт төрийн зохицуулалтыг сулруулах, хувийн өмчийн эрхийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, татварын хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг багасгаж улмаар корпорацид ээлтэй төсвийн бодлого хэрэгжүүлэх зэргийг 1997 оны Ашигт малтмалын тухай хууль⁴¹-иар нэвтрүүлэв. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого нь монголчуудад үнэ чөлөөлөх бодлого, мөнгөний ханш уналт зэргийг дагуулав.⁴² Үүний нийгэм эдийн засгийн үр дагаварыг Россоби (2005), Жаргалсайхан (2016) нар хангалттай тайлбарлаж дараахаар тоймлов: гиперинфляци тогтсон, ажилгүйдэл нэмэгдсэн, цалин 50% буурсан, иргэдийн орлогын ялгаа нэмэгдсэн, ядуурлын түвшинөөс доогуур орлоготой хүмүүсийн хувь хэмжээ 1990-2000 онуудад 16-аас 26 хувь хүртэл өссөн байна. (Hatcher 2016, Reeves 2011, Shagdar 2007, Дэлхийн банк 1994).

38 Hatcher 2016a, Rossabi 2005, Shagdar 2007.

39 ОУСБ, ялангуяа Дэлхийн банкны уул уурхайд дулдуйдсан эдийн засгийн хөгжлийн бодлогын талаарх мэдээллийг Hatcher 2012 and 2016 a, b -ээс үзнэ үү.

40 Lander, 2020: 93, citing Goyal, 1999: 636.

41 Hatcher 2016a,b; Jargalsaikhan, S. 2016, Reeves 2011, Rossabi 2005, Shagdar 2007.

42 Мөнгөний ханшны уналтын бүрэн хронологийг Shagdar 2007:3, based on Amarjargal 2002. In 1990 the USD1 = 5.6 MNT, in 1993 USD 1 = 400 MNT. Today, USD 1 = 2,629.93 MNT (3 April 2019).

Төрийн хяналт сул байдал ба ОУСБ-уудаас олгосон арвин санхүүгийн хөрөнгө нь ВНР, Айвенхоу Майнз, дараа нь Рио Тинтод зэрэг уул уурхайн компаниудын хөрш Хятадтай газрын дөт болон түүний өсөн нэмэгдэх эрдсийн хэрэгцээг нь харгалзан Монголын эрдэс баялагт нэвтрэх сонирхлыг үржүүлж байв.

Үндэстэн дамнасан уул уурхайн корпорациудад Монголд хөрөнгө оруулах урамшууллын бодлого явагдахын зэрэгцээ монголчуудад нийгмийн халамжит төрийн тогтолцоог нь татан буулгах явц нүүрлэж байв. Энэ үйл явц нь Монгол улсын нүүдэлчин хүн ам⁴³, нөөцийг нийтээр ашиглах түүхэн уламжлалтай ноцтой зөрчилдөж байв. Бямбажав (2012), Жаргалсайхан (2016) нарын тодорхойлсноор Монголын ард түмэн гурван хэмжүүрт алдагдалтай тулгарч үлдэнэ. Үүнд:

- ▣ ОУВС, Дэлхийн банкны хатуу нөхцлөлөөр гадаадын хөрөнгө оруулалтад чиглэсэн бодлогын шинэчлэл хийснээр **улсын гадаад өр нэмэгдэхэд** хүргэсэн:
- ▣ **Байгалийн баялгийг гаргаж авч** буй үндэстэн дамнасан корпорациуд хүрээлэн орчны сүйрэл, нийгмийн эмх замбараагүй байдал үүсгэдэг талтай
- ▣ Дээрх хоёр үр дагавар нь ашигт малтмал шавхагдаж, геологи ба гидрологи нөхөгдөшгүй өөрчлөгдөж улмаар биологийн олон янз байдал ба экологийн тогтвортой байдал алдагдахад хүргэж, Монголын соёлын өв болох нүүдэлчин ахуйн өвөрмөц байдал алдагдаж **ирээдүйн сонголт тодорхойгүй** болно.

Олборлох эдийн засагтай холбоотой сөрөг нөлөөлөл нь байгалийн баялгийн оронд хүрээлэн буй орчны доройтол, авлига, зөрчил, өр төлбөр зэргийг авчрах тул «баялгийн хараал» эсвэл «баялгийн занга» гэж нэрлэн тайлбарладаг нийт эдийн засгийн өсөлтийг бууруулахад хүргэдэг нөхцлийг хэлнэ. Гэтэл дээрх баялгийн хараалын тусгал нь өрөөсгөл бөгөөд институцийн түүхэн суурь, дэлхийн санхүүгийн тогтолцооноос их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хамгааллын хууль тогтоомжийг.

43 2014 онд SOMO-ийн тайланд Монгол улсад төмрийн хүдрийн уурхайгаас бий болсон сөрөг нөлөөний талаар бичиж байсан: <https://www.somo.nl/impacts-of-the-global-iron-ore-sector>, see also S. Dugersuren, 9 March 2015: <https://www.theguardian.com/global-development-professionals-network/2015/mar/09/mongolian-nomads-displacement-mining-impact-development-projects> (16/12/2019).

Дэлхийн банк ба баялгийн хараал

Дэлхийн банкнаас 2003 онд гаргасан Олборлох үйлдвэрлэлийн тойм тайлан⁴⁴ (ЕШ)-д баялгийн нөөц нь ховор тохиолдолд эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүргэдэг болохыг тодорхой харуулсан нь дэлхий даяар хийгдсэн судалгааны үр дүнгээр дэмжигдэж байна.⁴⁵ Тайлан нь баялаг ихтэй орнуудын олонхи нь зэвсэгт мөргөлдөөн, иргэний зөрчилдөөнд нэрвэгдэхээс гадна олборлох үйлдвэрлэлээс хараат байдал нь тухайн орны эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай байдгийг мөн тогтоожээ. Засгийн газар, корпорациудын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрүүд нь ирээдүйдээ байгаль орчин, нийгмийн хуулийн зохицуулалт хийх боломжийг нь хаах гольдролд оруулдаг аж.⁴⁶ Дэлхийн банк энэхүү таагүй дүн шинжилгээг үл тоомсорлон том уул уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх болон тус салбарын өндөр эрсдэлтэй⁴⁷ харгалзан гадаадын шууд хөрөнгө оруулалт татах үрэлгэн хөнгөлөлтүүдийг ухуулсаар иржээ.⁴⁸ Энэ нь уул уурхайн салбарыг хуулийн хяналтаас чөлөөлөх, либералчлах, олборлох салбарыг хувьчлах, татварыг хөнгөвчлөх, төрийн оролцоог таслан зогсоох, олон нийтийн хяналтыг багасгах бодлого болж хувирдаг байна.⁴⁹

Hatcher (2012:428)⁵⁰ -д ДБ-наас Азид, ялангуяа Монголд нэвтрүүлж буй тогтолцоонд төрийг ухрааж хувийн хэвшлийн хяналт, зохицуулалтыг дэмжиж, улмаар тодорхой «Уул уурхайн улс төр»-ийг хэрхэн өрнүүлж байгааг харуулж байна. Ландер саяхны (2020, х.104) бүтээлдээ ийм неолиберал улс төрийг Монгол мэт улс орнуудад өрийн санхүүжилтийн сахилгын механизм болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хараат байдлаар нь дамжуулж суулгаж өгдөг бөгөөд тэр нь гадаад зах зээлд захирагдах зохицуулалтын хандлагатай уялдсан байдаг гэж тайлбарлажээ. Дэлхийн банкны группийн нэг болох Олон улсын хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (MIGA) нь улс төрийн эрсдлийн баталгааг гаргаж, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэн ажиллаж байна. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)⁵¹ болон бусад эрдэм шинжилгээний⁵² судалгаагаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нь улс орны хөгжилд ашиг тустай, мөн үндэстэн дамнасан байгууллагуудыг татан оролцуулах либерал бодлого нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг гэх төсөөлөлд нотолгоо олоогүй. Бесада ба Мартин (2013) нар эрсдэс баялгаар баян

44 Salim, E. 2003.

45 Bebbington et al 2008, Salim, 2003, Rosser, 2006.

46 Salim, E. 2003: p.27

47 Salim, E. 2003: p.30

48 Hatcher, P. 2012.

49 Salim, E. 2003, p.28

50 Hatcher, P. 2012.

51 Agosin and Mayer, 2000.

52 Alfaro et al 2002, Carcovic and Levine 2002; Lyroudi et al, 2004, Borensztein, De Gregorio and Lee, 1998.

Африкийн орнуудын талаар юу ярьж байсан нь өнөөгийн Монгол дахь нөхцөл байдлыг харуулсан мэт байна:

«Олон улсын хандивлагчид ба санхүүгийн байгууллагуудын шахалт, тусгаар тогтнол олсны дараахан уул уурхайн салбарт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дорвитой үйл ажиллагаа явуулж чадаагүй байдал нь Африк тив даяар уул уурхайд либералчлагдсан хууль тогтоомжийг өргөн хүрээнд нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр реформууд нь ихэнх тохиолдолд төрийн «эзэмшигч-оператор» үүрэгролийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг «дэмжигч» болгон хязгаарлаж өгсөн. Байгаль орчныг хамгаалах, нийгмийн хамгаалалд чиглэсэн байгалийн нөөцийн менежментийн стратеги нь эдгээр хууль тогтоомжийн өөрчлөлтүүдэд заалттай хэвээр үлдсэн боловч хувийн хэвшлийн операторуудын «өөрийн дотоод зохицуулалт»-аас ихээхэн хамааралтай болов.»⁵³

Дүгнэж хэлэхэд, уул уурхайн сөрөг нөлөөлөл ба түүнийг ОУСБ-ын зүгээс үгүйсгэх идэвхтэй үгүйсгэл хоёул өнөөгийн дэлхийн улс төр-эдийн засгийн тогтолцооны бодит байдал мөн.

2.2 Монголд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах нь

1991-2012 оны хооронд Дэлхийн банк нь уул уурхайд холбоотой бараг 193 сая долларын өртөг бүхий 9 төслийг санхүүжүүлсэн бөгөөд 6 нь хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалтад таатай (орон нутгийн үйлдвэрлэл, төрийн секторын хөгжлийн биш) уул уурхайн бодлого боловсруулахад чиглэгдсэн байдаг.⁵⁴ Үүний үр дүнд 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, 1997 оны Ашигт малтмалын тухай хууль батлагдаж хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбарчилсан, хөрөнгө оруулагчдын эрх, эд хөрөнгийг хамгаалснаар гадаадын хөрөнгө оруулалтыг хөнгөвчилсэн. Уул уурхайд оруулах гадаадын хөрөнгө оруулалтад хүчийг төвлөрүүлэх нь Монгол Улсыг түүхий эдийн үнийн хэлбэлзэл болон ГШХО-ын цочролд өртөмтгий болгосон.⁵⁵ Үүгээр зогсохгүй, МУ-ын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ноос гаргасан мэдээлэлд уул уурхайн салбарын ажил эрхлэлт 2019 онд нийт ажил эрхлэлтийн өчүүхэн 2.11%-ийг⁵⁶ эзэлж (2016 оны 3.6 хувиас буурсан⁵⁷) байна.

Оюу Толгойн уурхай нь ГШХО-ыг татахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 2009 онд ОТХОГ байгуулснаас хойш тогтвортой нэмэгдэж 2011 онд дээд цэгтээ хүрсэн юм.⁵⁸ Уурхайгаас олох орлого нь урт хугацаанд Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн түлхэц

53 Besada, H & P. Martin (2013), p.10.

54 Hatcher, Pascale (2014)

55 Baatarzorig, T. et al, 2018, мөн Дэлхийн банкны вебсайт, <https://www.worldbank.org/en/country/mongolia/overview> (2018-12-22).

56 ҮСХ, 2019/2, МУ-ын нигэм-эдийн засгийн байдлын илтгэл.

57 Т. Батзориг ба, et al, 2018, х.527.

58 Development Finance Assessment for Mongolia Diversifying finance for sustainable development (2018) <http://www.asia-pacific.undp.org/content/dam/rbap/docs/dg/dev-effectiveness/RBAP-DG-2018-Development-Finance-Assessment-Mongolia.pdf>, p. 40 (22-11-2018).

өгнө гэж ярьдаг тул уурхайтай холбоотой шийдвэрүүд нь Монголын бодлого, улс төрд хүчтэй нөлөөлдөг юм. 2012 оны сүүлээр TRQ уурхайн өртөг зардлыг 2 тэрбум доллароор хэтрүүлснийг мэдээлэхэд МУ-ын Засгийн газраас тайлбар шаардсан асуулга тавихад Рио Тинто дараах байдлаар хариу барьсан байна. Үүнд: *«далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт, бүхажил эдгээр асуудлууд дуусгавар болж, шинэ цагийн хуваарь батлагдах хүртэл хойшлогдоно.»*⁵⁹ гэжээ.

«Рио Тинто» -г дагаад бусад уул уурхайн корпорациуд олборлох гэрээгээ цуцалжээ⁶⁰. Үүний үр дүнд ГШХО ихээхэн буурч, мөн түүхий эдийн үнэ давхцан буурсан нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17% байснаас 2014 онд ердөө л 8% болсонд нөлөөлжээ.⁶¹

Рио Тинто болон Засгийн газрын хооронд үүссэн хурцадмал харилцаа⁶² нь 2015 он хүртэл шийдэгдээгүй⁶³ хэвээр байх зуур 2013 онд ГШХО буурсантай холбогдуулан МУ гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүү татсан, тэдний өмчийн эрхийг нэмэгдүүлсэн⁶⁴ Хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулийг батлажээ. Цуцлагдсан 2012 оны Хөрөнгө оруулалтын тухай хууль (БЕРИ)-тай адилгүй шинэ хөрөнгө оруулалтын хууль нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил хамгаалалтанд авч, гадаадын хувийн хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг хялбаршуулж, татварыг хөнгөвчилжээ: «Энэхүү хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгө оруулагчдын эрх, сонирхлыг хуулиар хамгаалах, хөрөнгө оруулалтад хуулийн нийтлэг баталгаа гаргах, хөрөнгө оруулалтыг хөхүлэн дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг мөн хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлох ба хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулах.» (Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 1-р зүйл)⁶⁵. Энэхүү хуулийн дагуу байгуулагдсан Invest Mongolia агентлагийн дарга Жавхланбаатарын Сэрээтэр⁶⁶ нь 2013 оны ярилцлагадаа энэхүү хууль нь ОТ уурхайг санхүүжүүлэх ГШХО нэмэгдүүлнэ гэж найдаж байгаагаа

59 <https://www.reuters.com/article/mongolia-riotinto-financing-idUSL4N0FZ1M620130729>, үзсэн (2018-09-07).

60 Lazenby, H. 2012, http://www.miningweekly.com/article/turquoise-hill-rejects-review-mongolian-of-mining-contract-2012-10-15/rep_id:3650 (2018-09-07).

61 It fell rockbottom to 1% in 2016, but has since recuperated to 5%, Дэлхийн банкны вебсайт, <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.МКТР.KD.ZG?end=2018&locations=MN&start=1996> (2019-12-10).

62 2012 оны сонгуулиар байгалийн баялгийн хяналтыг сайжруулахыг шаардсан нийтийн дэмжлэгтэй АН ялж. Стратегийн салбар дах ААН-ийн гадаад хөрөнгө оруулалтыг (SEFIL) 2012 оны 5-р сард баталсан бөгөөд зарим салбар, түүний дотор уурхайд хөрөнгө оруулалт ба өмчлөлийн хязгаарлалт 49% тогтоосон бөгөөд уул уурхай ба банк санхүүгийн салбарт аливаа эзэмшлийн өөрчлөлтийг УИХ батлахаар хуульчилсан. Уул уурхай ба санхүүгийн салбар нэгэн дуугаар, Дэлхийн банкны хамт МУ-ыг баялгийн үндсэрхэх үзэлд буруутгав. 10-р сарын ЗГ ОТ дахь өөрийн эзэмшлийг 34-өөс 40% -д хүргэх, роялтигийн 5%-ийг 20% хүртэл хувьсах хүү болон ашгийн татварын хөнгөлөлтийг цуцлах санал гаргасан.

63 Бүрэн эхээр Lander 2013 ба НҮБХХ 2018, Development Finance Assessment for Mongolia Diversifying finance for sustainable development (2018) <http://www.asiapacific.undp.org/content/dam/rbap/docs/dg/dev-effectiveness/RBAP-DG-2018-Development-Finance-Assessment-Mongolia.pdf>, p. 41, (22-11-2018). For the law itself: <https://www.mofa.gov.mn/new/images/banners/regulation/investmentlaw.pdf> (2018-09-07).

64 Бүрэн эхээр J. Landers (2020)-ийг үзнэ үү.

65 МУ-ын хөрөнгө оруулалтын тухай хууль http://crc.gov.mn/contents/en/raw/12/30/34/19._Law_on_Investment.pdf (2018-09-07).

66 Dettoni J, 2013-11-27, <http://thediplomat.com/2013/11/sereeter-javkhlanbaatar/> (2018-09-07).

илэрхийлэв. Байгалийн баялгийн удирдлагын хүрээлэн (NRGI) нь 2015 онд хэрхэн тохиролцоонд хүрч, ОТ уурхайн гүний 2-р үе шатанд шаардлагатай санхүүжилтийг гаргасан бүх үйл явцад дүн шинжилгээ хийжээ⁶⁷. Тэд 2012 оноос хойших зэсийн үнийн уналт, БНХАУ-д баяжмалын эрэлтийн бууралт болон ГШХО-ын бууралт Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн шинэчлэл хийх эрмэлзлийг алдагдуулсан гэж тэд дүгнэжээ.

Энд олон жилийн туршид байгалийн баялгаас хараат зах зээлийн эдийн засаг байгуулах зорилготой хийсэн бүтцийн өөрчлөлтүүд нь эрдсийн үнийн хэлбэлзэлд туйлын мэдрэмтгий болгож улмаар Рио Тинто мэт глобал корпорацуудад энэхүү эмзэг байдлыг өөрсдийн ашиг хонжоо болгон ашиглах боломжийг нэмдэг гэдгийг бид харууллаа.

67 Shafae A, 2015-06-24, <https://resourcegovernance.org/blog/rio-tinto-mongolia-and-art-negotiating-amidst-price-volatility> (2017-12-07).

3 Монгол ба ОТ: Хөшигний цаагуурх тулгалт

7-р сарын сүүлд завсарлах Улсын Их Хурлын зуны амралтын өмнөхөн «...олон нийтийн зөвхөн 80 хувь нь төлөвлөгөөг эсэргүүцвэл бид азтай гэж үзнэ гэж Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч. Хүрэлбаатар сэм хошигнов, тэрээр Засгийн газрыг төлөөлөх гол хэлэлцэгч бөгөөд [Оюу толгойн] гэрээг аль болох чимээ багатайгаар ЗГ ба парламентад оруулж хариулан байж батлуулахаар идэвхтэй зүтгэж буй хоньчин юм.»

АНУ-ын ЭСЯ, 2007 оны 7-р сар, дипломат цахилгаан мэдээ, Улаанбаатар, Монгол улс⁶⁸

Wikileaks-т цацагдсан МУ-д суугаа Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-наас 2006-2010 онуудад илгээсэн дипломат цахилгаан мэдээнүүд дэх мэдээлэл нь ОТ-тэй хэлэлцээр байгуулахад МУ-н Засгийн газар хэрхэн дарамтлагдан хөтлөгдсөн тухай ойлголтыг өгнө. Энэхүү цахилгаан мэдээнүүдээс хэлэлцээрт оролцогч талууд ямар аргументыг гаргаж, эдийн засаг, геополитикийн ашиг сонирхлыг хэрхэн, яаж тоглолтод оруулдаг нь харагдах болно. Засгийн газар нь Оюу Толгойн улс төр, эдийн засгийн хэрээс хэтэрсэн ачааллыг зохицуулахын төлөө тэмцэлдэж байх үед, уул уурхайн компаниудтай санал хамссан «барууны» эдийн засгийн хэд хэдэн ашиг сонирхол Монголд хохирол учруулахаар зэхэж байв. Үүний үр дүнд үндэсний болон олон улсын хүчирхэг тоглогчид Рио Тинто, Айвенхоу Майнз нартай хамсаж олон улсын корпорацийн ашиг сонирхлыг Монголын нийтийн хэрэгцээнээс дээгүүр тавьсан тохиролцоонд хүргэхээр Монголд шахалт үзүүлэв. Энэхүү цахилгаан мэдээнүүдэд Монголын улстөрчид Оюу Толгойн гэрээг гадаадын ашиг сонирхолд худалдсан мэт харагдуулахгүйгээр байгуулахыг хичээж байсныг мөн илчилнэ.

Энэ бүлэгт эхлээд ОТХОГ хэлэлцээний товч хронологийг харуулж, мөн дараа нь АНУ болон «барууны» хэд хэдэн гүрнүүд хэлэлцээнд хэрхэн оролцож, нөлөөлсөн тухай АНУ-ын элчин сайдын яамны цахилгаан мэдээний тусламжтайгаар хийсэн дүгнэлтийг өгнө. Энэ нөлөө нь ОУВС-гийн Монгол улсад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг рүү хөтлөх ба хамтдаа Оюу Толгойн хөрөнгө оруулагчдад хэрхэн ашигтайгаар буухыг харуулна. Эцэст нь Монголын улс төрчид улс төрийн ашиг хонжоо эрэлхийлэхдээ эдийн засгийн ашиг сонирхлоо, улсын нийтийн хэрэгцээ зэргээр хэрхэн жонглөрдсөн тухай зарим ойлголтыг өгнө.

68 УИХ-аар Оюу Толгойн маргаантай гэрээг хэлэлцэх явц эсэргүүцэл дагуулсаар https://wikileaks.org/plusd/cables/07ULAANBAATAR425_a.html#help_2p (April 18, 2019).

2003-2010 оны хооронд явагдсан Хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээний хронологи

Айвенхоу Майнз ба МУ-ын ЗГ-ын хооронд ХО-ын талаар хийсэн хэлэлцээ нь 2003 онд Оюу Толгойн зэс, алтны ордны хэмжээ, чанар нь дэлхийн хамгийн том зэс, алтны ордуудын нэг болохыг тогтоосноор эхэлсэн юм⁶⁹. Тухайн үед ерөнхий сайдын алба хашиж байсан Энхбаяр тохиролцоонд хүрэх нааштай хандлагатай байв. Энэ хугацаанд Айвенхоу Майнз компани нь ВНР-ийн хайгуулын эрхийг 100% эзэмшилдээ авч, 238 км² талбай бүхий ашиглалтын лицензийг 60 жилийн хугацаатай, мөн дахин 40 жилээр сунгах эрхтэй авсан байв⁷⁰. Тохиролцоог урагшлуулах зорилгоор Айвенхоу нь 2003 онд ОХУ-д төлөх зөвлөлтийн үеийн өрийг дарах зорилгоор 50 сая ам.долларын зээлийг ЗГ-т олгожээ.⁷¹ Гэсэн хэдий ч монголчууд уурхайгаас олсон орлогын хуваарилалт, баялгийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, Хятадын хөрөнгө оруулагчид буюу түншүүдийн оролцоо ямар байх зэрэг эргэлзээтэй асуудлууд байсан тул ОТХОГ-г зураагүй байна.

2006 оны 5-р сард Монгол Улсын парламент зэс, алтны тус бүрийн борлуулалтын үнэ нь 2600 доллар/тонн, 500 доллар/унцинаас дээгүүр гарсан орлогод 68 хувийн «гэнэтийн ашгийн» татвар ногдуулах хууль гаргав.⁷² Энэхүү татварыг Монголд хайлуулж буй хүдэрт ашиглахгүй тул Монгол Улсад нэмэгдсэн өртөг шингэсэн боловсруулалтыг дэмжихэд оршиж байсан юм.⁷³ Хоёр сарын дараа, 2006 оны 7-р сард Уул уурхайн тухай шинэ хууль батлагдаж, уул уурхайн томоохон гэрээг батлах эрх мэдлийг засгийн газраас парламентад шилжүүлэв. Цаашилбал, энэ хууль нь Монголын ГЗ-т хувийн хайгуулаар тогтоогдсон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын 34 хүртэлх хувийг, мөн улсын төсвийн хөрөнгөөр нээсэн ордын 50 хүртэлх хувийг эзэмших эрхийг олгов.⁷⁴ Үүний зэрэгцээ олборлосон ашигт малтмалын нөөц ашигласны татварыг 2.5% -иас 5% болгон нэмэгдүүлж, алдагдал гарсан тохиолдолд хоёр жилийн дараа татвараас хасч тооцох болсон. Хэдэн сарын дараа, 2006 оны 10-р сард, Рио Тинто Оюу Толгойн барилга ба ашиглалтын асуудлаар Айвенхоу Майнзтай стратегийн түншлэлийн харилцаа үүсгэснээр хэлэлцээнд орж Монголын талтай гэрээнд хүрэхгүй бол зугтах заалтыг тохиров⁷⁵.

69 Айванхое Майнз, 2003-02-26 https://www.turquoisehill.com/site/assets/files/4775/03feb26_longsection.pdf (2017-12-08).

70 Айванхое Майнз, 2003-12-23 https://www.turquoisehill.com/site/assets/files/4701/2003-12-23_nr.pdf (2019-04-04).

71 Айванхое Майнз, 2004-08-23 https://www.turquoisehill.com/site/assets/files/4701/2003-12-23_nr.pdf (2019-04-04).

72 USGS, 2006, Ашинт малтмалын жилийн мэдээлэл <https://s3-us-west-2.amazonaws.com/prd-wret/assets/palladium/production/mineral-pubs/country/2006/myb3-2006-mg.pdf> (2018-09-07).

73 Ройтерс, 2009-08-20 <https://www.reuters.com/article/mongolia-mining/mongolia-lawmakers-seek-metals-windfall-tax-repeal-idUSPEK21383720090820>.

74 МУ-ын Хөрөнгө оруулалтын хууль, 2006-07-08 <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/mon149656E.pdf> (September 7, 2018).

75 Айванхое Майнз, 2006-10-18, https://www.turquoisehill.com/site/assets/files/4448/2006-10-18_nr.pdf.
Parkinson, D., 2006-10-18, <https://www.theglobeandmail.com/report-on-business/ivanhoe-mines-soars-on-rio-tinto-deal/article20415539/> (September 7, 2018).

АНУ-ын ЭСЯ-ны цахилгаан мэдээ нь яриа хэлэлцээ 2007 онд эрчимжиж 2007 оны 6-р сарын 26-нд Засгийн газрын шийдвэр гарсныг мэдээлж байна⁷⁶. Үүний дараа тухайн үеийн ерөнхийлөгч Н.Энхбаяр уурхайн 51 хувийг эзэмшихийг шаардаж асуудлыг зогсонги байдалд оруулав. 2008 он гэхэд энэхүү 51 хувийн эзэмшлийн шаардлага улс төрийн намууд МАХН, АН аль алины дэмжих нөхцөл болов. Гэсэн хэдий ч Айвенхоу Майнз, Рио Тинто нар үүнийг эрс эсэргүүцэв⁷⁷. Харилцаа муудаж, бүх хэлэлцээг 2008 оны сонгуулийн дараа болтол хойшлуулав. Гэвч сонгууль жагсаал цуглаан, үймээнээр дуусч, дөрвөн хоногийн онц байдал зарлагдаж, 5 хүн амь үрэгдэж, 300 хүн шоронд хоригдлоо.⁷⁸

оны санхүүгийн хямрал Монгол улсыг нөмөрч хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч, зэсийн үнэ буурсан нь улсын эдийн засгийг сулруулахаас гадна Монгол Улсын хэлэлцээ хийх байр суурийг сулруулан хэлэлцээний ширээнд эргэн суухад хүргэв.⁷⁹

Уул уурхайн салбарын гэрээ, хэлэлцээрийн загвар боловсруулах 9,3 сая долларын өртөгтэй техникийн туслалцаа төслийг Дэлхийн банкнаас эхлүүлэх тэр үед ЗГ хөрөнгө оруулалтын гэрээний техникийн нөхцөлийг боловсруулах Ажлын хэсэг байгуулж байв. Мөн тэр үед Айвенхоу, Рио Тинто нар ОТ-н ажиллах хүчний 40 хувийг халж, ОТ болон Тавантолгойн гэрээг эцэслэх шахалтыг үзүүлэв.

2009 оны эхээр МУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл уг хэлэлцээрийг дэмжих шийдвэрийг хоёр нэгийн саналаар гаргалаа⁸⁰. Энэхүү хэлэлцээрийг 2009 оны 3-р сард парламентад оруулсны дараахан 4-р сард ОУВС-гийн дөрөв дэх зээлийн багцаа, ДБ нь 40 сая ам.долларын хөгжлийн зээлийг олгох боллоо. 2009 оны 8-р сар гэхэд Айвенхоу ба Рио Тинто компаниуд орлогын албан татварыг хөнгөлөх, хоёр биш харин найман жилийн туршид⁸¹ учирсан алдагдлыг нөхөхөөр амжилттай тохиролцож, 2006 оны гэнэтийн ашгийн татварыг хүчингүй болгох нөхцөлтэйгээр ОТ төсөл хэрэгжих боломжтой боллоо. ОТХОГ байгуулахаас өмнө нийтдээ 4 хуульд өөрчлөлт оруулж, дараа нь 7 хуульд нэмэлт өөрчлөлт оруулав⁸².

76 УИХ-аар Оюу Толгойн маргаантай гэрээг хэлэлцэх явц эсэргүүцэл дагуулсаар https://wikileaks.org/plusd/cables/07ULAANBAATAR425_a.html (2019-04-17).

77 2007 Олборлох салбарын тойм: Нэг алхам урагш, хоёр хойш https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-04-17).

78 Bulag, U. E. 2009. Монгол 2008 онд: Монголоос Майнголия руу. Asian Survey 49 (1): 129-34.

79 Дэлхийн санхүүгийн хямрал Монгол дахь уурхайн эсэргүүцлийг сааруулав, 2008-12-01 https://wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR521_a.html (2019-04-17).

80 Монгол дахь уул уурхайн маргаан ерөнхийлөгчийн хүч мөхөсдөж байгааг илэрхийлэх нь 2009-03-03 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR87_a.html (2019-04-17).

81 2009-08-25 <https://www.reuters.com/article/mongolia-ivanhoe-tax-idUSPEK9463520090825>, Behman, E 2009-08-26, <https://www.marketwatch.com/story/mongolia-clears-way-for-oyu-tolgoi-mine-2009-08-26> (2017-07-07).

82 УУЭХЯ, https://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Zorigt_ENG.pdf (2019-04-17).

Уурхайн усны хүртээмж, ашиглах эрхийг хөнгөвчлөх үүднээс Усны тухай хуульд өөрчлөлт оруулав⁸³. Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд зааснаар Оюу Толгой нь «стратегийн орд» тул ОТ-ийн усыг ашиглах эрх (ердийн 20 жилийн оронд) 30 жил үргэлжилнэ. Мөн энэ эрхийг 20 жилийн хугацаатай сунгаж болно (бусад нь зөвхөн 5 жилийн сунгах эрхтэй). ОТХОГ-д зааснаар «өөрөө хайж нээсэн» усны нөөцөөс «төслийн ашиглалтын шаардлага» -д нийцсэн секундэд 870 литрын (ОТХОГ 6.13.1) хэмжээнд барин татвараас чөлөөлөгдөн (ОТХОГ, 6.14) ашиглах боломжтой. Энэ нь үнэн хэрэгтээ ОТ-г хувийн усны эх үүсвэртэй болгож усны зардлыг нь нийт татвар төлөгчид үрүүлсэн гэсэн үг.

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд⁸⁴ албан ёсоор гарын үсэг зурах ажиллагаа 2009 оны 10-р сард явагдав. Дэлхийн банк уг гэрээг «ирээдүйн уул уурхайн төслүүдийн загвар гэрээ болно»⁸⁵ гэж сурталчилав.

ОТХОГ-д гарын үсэг зурсны дараа ОТ төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг босгохын тулд Айвенхоу Майнз компани Рио Тинтогоос нэмэлт санхүүгийн дэмжлэг ба оролцоог эрэлхийлэх шаардлага үүсчээ. Рио Тинто ОТ уурхайн оператор болохоос гадна Айвенхоугийн хувьцааг худалдаж авч төслийн санхүүжилтийг олоход тусална. 2011 онд Эрдэнэс ХХК, Айвенхоу Оюу Толгой ХХК, Нидерландын Оюу Толгой Б.В, Оюу Толгой ХХК нь хувьцаа эзэмшигчийн шинэ гэрээ байгуулжээ. Мөн жил ДБ 25 сая долларын Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (МШ1Б)-ийг эхлүүлж, зэсийн үнэ ч дээд цэгтээ хүрсэн энэ үед Монгол Улсын өсөлт 17,3% -д хүрэв.

Яг энэ үед Рио Тинто Айвенхоу Майнз компанийг өөрийн хүслийнх эсрэг залгин⁸⁶ авах хүслээ ил болгов. 2012 оны 1-р сард Рио Тинто Айвенхоу Майнз -ын дийлэнх хувьцаа эзэмшигч болж компанийн нэрийг Turquoise Hills Resources (TRQ) болгон өөрчилжээ.

83 Усны тухай хуулийг өөрчилсний байгалийн болон нийгмийн үр дагаврын тухай: Jackson, S.L. 2018. Abstracting water to extract minerals in Mongolia's South Gobi Province. *Water Alternatives* 11(2): 336-356.

84 ОТХОГ 2009, https://www.ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_EN.pdf (September 7, 2017).

85 Дэлхийн Банк, 2009, <http://documents.worldbank.org/curated/en/440051468053404598/pdf/ICR12820P115737.pdf>, x.15 (2017-12-07).

86 Paul S, 2011-12-13 <https://www.reuters.com/article/us-ivanhoe-rio/rio-tinto-wins-fight-against-ivanhoe-poison-pill-idUSTRE7BC0A420111213>, MacNamara, W. Jan 18, 2012, <https://www.ft.com/content/17a3b0fc-41f5-11e1-9506-00144feab49a> (2019-12-07).

3.1 Хаалганд шургуулсан хөл: АНУ-ын сонирхлыг Монголд тэлэх нь

АНУ-ын Элчин сайдын яам нууцлал алдагдсан цахилгаан мэдээнүүддээ өөрийгөө Монгол улс ба Оюу Толгойн хөрөнгө оруулагчдын хооронд зуучлагч хэмээн тодорхойлон удаа дараа бичжээ. Элчин сайдын яам -ДТГ (дипломат төлөөлөгчийн газар)- өөрийн дипломат хүчин чармайлтаа дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

«Сүүлийн зургаан жилийн хугацаанд (2004-2009) ДТГ нь бизнес, ЗГ-тай найдвартай харилцаа тогтоож, аль аль талд туйлшралгүй, найдвартай, шударга гэж үнэлэгдэх тоглогч болохоо харуулж чадлаа. Эдгээр чанар нь ДТГ[АНУ-ын Элчин Сайдын Яам] ийг зорилго хүсэлтээ нотолгоожуулах (үнэнийг олох) эцсийн цэг мэт болголоо.»

2009 оны 8-р сар⁸⁷

АНУ нь Монгол улсын засгийн газар ба Оюу Толгойн хөрөнгө оруулагчдын хоорондын харилцаанд зуучлагч хийхийн сацуу Оюу Толгойн бүтээн байгуулалтанд өөрийн сонирхол байгаа нь илт. Элчин сайдын яамны ажилтныг иш татвал, 2009 оноос өмнө ОТ-тэй тохиролцоонд хүрч чадаагүй нь «200 сая амдолларын өртөг бүхий АНУ-ын тоног төхөөрөмжийн борлуулалт болон бусад гэрээний экспортын ашиг алдагдсан»⁸⁸ гэжээ. ОТ нь Монголд бизнес эрхлэх боломжтойг харуулсан анхны томоохон уул уурхайн гэрээ байсан бол АНУ-ын нүүрс олборлогч Peabody Energy компани нь Оюу Толгойг эрчим хүчээр хангах нүүрсний уурхай болох Тавантолгойг нүдэлж байсан.⁸⁹

«Peabody Energy, Рио Тинто зэрэг уул уурхайн компаниуд, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Caterpillar, Ingersoll-Rand, Buyrus, and John Deere компаниуд буюу АНУ-ын худалдааны ашиг сонирхлын үүднээс харвал урт хугацаанд АНУ-ын бараа, үйлчилгээг худалдан авч тогтвортой орлоготой байлгах боломжийг Монголд бүрдүүлэх салбар нь уул уурхайн салбар мөн.»

2009 оны 7-р сар⁹⁰

Оюу Толгойн яриа хэлэлцээ нь Рио Тинто, Peabody Energy компанийг лоббидох замаар АНУ-ын эдийн засгийн оршихуйг нотлох⁹¹, дипломат байр сууриа бэхжүүлэхэд туйлын тохиромжтой хэрэгсэл болов:

87 Монголын парламент удал хүлээсэн уурл уурхайн чухал гэрээг батлав https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-06-17).

88 2009-07-30 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR208_a.html (2019-06-17).

89 2008-02-06 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-06-17).

90 2009-07-30 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR208_a.html (2019-06-17).

91 NAMBIC (North-America Mongolia Business Council) was for many years led by former USAID consultants. Lead lobby institution, which is now re-named Mongolia Business Council and is led by a Mongolian.

«Худалдааны Департамент нь Peabody болон Rio Tinto-д Төлөөлөх төвөөрөө дамжуулан сурталчлан таниулах дэмжлэг үзүүлсэн нь Тавантолгой ба Оюу Толгой дахь тэдгээрийн оролцоо нь АНУ-ын үйлдвэрлэгчдэд урт хугацааны экспортын боломж олгож байгааг үнэлсэн ба АНУ-ын чөлөөт зах зээл ба ардчиллын зорилтыг Монгол Улсад х зорилгод нийцсэн хэрэг мөнийг нотлов.»

2008 оны 2-р сар⁹²

АНУ-ын элчин сайдын яам нь Монголын ЗГ, Рио Тинто компани хоёрын хэлэлцээ хийх чадавхид ихээхэн зөрүү байгааг мэдсээр байж компанийн талд орж дэмжлэг үзүүлсэн юм. Дипломат мэдээлэлд Уул уурхайн, эрчим хүчний яамны ажилтнууд илэрхийлсэн:

«(олон жил МУ-ын уул уурхайн салбарыг ажигласан нэгний хэлснээр) өнгөрсөн хэлэлцээрүүдэд Рио Тинто мэт корпорацуудын хэлцлийн ширээнд суулгасан туйлын чадварлаг агентууд нь эмгэнэлтэй нь аргагүй сайн дурын уран сайханч монголчуудыг тамлах шиг л болсон гэж илгээлтдээ мэдээлж байв.»⁹³

АНУ-ын ЭСЯ нь улс төрийн жингээ санаатайгаар Рио Тинтогийн талд үйлчлүүлснээр Рио Тинто ба МУЗГ-ын хэлэлцээний чадавхийн зөрүүг улам нэмэгдүүлж, Монгол Улсын байр суурийг сульдуулав.

2009 онд хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсны дараа ЭСЯ-ны ажилтнууд үүнийг *«АНУ-ЫН худалдааны дипломатууд нь Монгол Улсад ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг боловсруулахад гол тоглогчдын дунд АНУын байр суурийг баталж чадлаа.»⁹⁴* гэжээ. Оюу Толгойн уурхай, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд АНУ-ын Fluor Corporation гэх 2000 хятад ажилчинтай барилгын компанитай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулагдсан.⁹⁵

ЭСЯ-ны хийсэн дүгнэлтээр 2008 оны эдийн засгийн дарамт нь Засгийн газрыг өөрийн болон Рио Тинто, Айвенхоу Майнз компаниудын хооронд тэнцвэртэйд тооцогдож болох тохиролцоонд хүрэхэд түлхсэн гэж дүгнэв. МУ-ын Засгийн газар хэт их буулт хийсэнд санаа зовнисон зарим хандивлагч орнуудын сэм яриаг ЭСЯ цахилгаан мэдээндээ товч дурдсан болжээ.⁹⁶

92 2008-02-06, https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-04-26).

93 2008-12-01, https://wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR521_a.html (2019-06-17).

94 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-06-17)

95 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-06-17)

96 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-06-17)

3.2 OT-н төлөөх гаднын зохион байгуулалттай лобби

Монгол Улсын Орос, Хятад хоёрын хооронд буй газарзүйн байрлал нь түүнийг геополитикийн хувьд чухал улсын тоонд багтаадаг. Хоёр хүчирхэг хөрш – Орос, Хятад – аль алины эрхшээлээс зайлсхийхийн тулд Монгол «Гуравдагч хөршийн бодлого» гэгч бодлогыг нэвтрүүлэв. Энэхүү бодлого нь газарзүйн хөрш орнуудынхаа нөлөөллийг тэнцвэржүүлэх үүднээс бусад улстай дипломат харилцаа холбоог бэхжүүлэхэд оршино.

АНУ нь Оюу Толгойг тухайн бүс нутагт өөрийн байр суурийг бэхжүүлэх хөшүүрэг болгон ашиглаж, Монголын Засгийн газарт дараахь зүйлийг анхааруулж байна. Үүнд:

«Хятад, Оросын нөлөөллийг тэнцвэржүүлэхийн тулд барууны компаниуд (мөн тэдгээрийн засгийн газрууд)-ыг оруулахгүй бол Монгол Улс эдийн засгийн хараат бус байдлаа өмчлөх ба түүнийг ашиглах эрх авсан аль нэг хөршдөө алдахаас өөр аргагүй байдалд хүрнэ.»
2008⁹⁷

Хэд хэдэн хандивлагч орны дипломат төлөөлөгчид болон тус улсад үйл ажиллагаа явуулж буй 'барууны' бизнесийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтад Их Британийн Монгол дахь Элчин сайд гуравдагч хөршийн бодлогын нөлөөг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

[Монголдахь ИхБританийн элчин сайд] «Монгол Улс «гуравдагчхөрш» бодлогынхоо хэрэглээгзөв олоогүй байгааг тэмдэглэе. Хатан хааны засгийн газар Монголтой харилцаа харилцааныхаа түвшинг эргэж харах гэж байгаа нь Их Британид Монголын газар нутагт барьцтай зүйл алга. Хэрэв Монгол Улс Их Британитай харилцаагаа цаашид үргэлжлэх эсвэл өргөжүүлэхийг хүсч байвал Британийн хөрөнгө оруулалтыг татахад шаардлагатай бүхий зүйлийг хийх хэрэгтэй. Хэрэв Монгол Улс Их Британи, АНУ, Канад, Япон гэх мэт улсын хөрөнгө оруулалт, улс төрийн дэмжлэгтэйгээр Хятад, Оросыг тэнцвэржүүлэхийг үнэхээр хүсч байвал хөрөнгө оруулах таатай орчныг бүрдүүлж, тогтвортой байлгах хэрэгтэй.»
2008 оны 2 сар⁹⁸

АНУ нь Монголыг уг хэлэлцээрт уриалахад голлож байсан боловч ганцаараа дипломат арга хэрэглээгүй. 2008 оны 1-р сард Канад улсын тэр үеийн Олон улсын худалдааны сайд Дэвид Эмерсон Монголд айлчилж, Монгол улсын ЗГ-ын төлөөлөгчид, олон улсын дипломатууд, Монголд үйл ажиллагаа явуулдаг корпорацуудын төлөөлөлтэй уулзалт хийв. Хойд Америк- Монголын Бизнесийн Зөвлөл гэх – Монгол дахь үндэстэн дамнасан компаниудын төлөөллийн сонирхлын бүлэгээс зохион байгуулж олон дипломатч, бизнесийн төлөөлөгчдийн оролцуулсан нэг уулзалтад эдгээр тоглогчид өөрсдийн ашиг сонирхлыг дээд хэмжээнд нийцүүлэн Монголд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийн талаар хэлэлцүүлэг өрнөв:

97 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-06-26).

98 2008-02-06 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-04-26).

«1-р сарын 10-ны өглөөний цайны үеэр Эмерсон сайд ба түүний төлөөлөгчид МУЗГ-аас уул уурхайд хандах хандлагын талаар төрөл бүрийн санал бодлыг сонслоо. Уул уурхайн төлөөлөгчид сайдад тууштай мэссэжүүдийг хүргүүлэв. Компаниуд өөрсдийн бизнесийн арилжааны талыг шийдвэрлэх чадвартай бөгөөд бэлэн байгаага мэдэгдэж харин засгийн газрууд хамтарсан, нэгдсэн фронт бүрдүүлэн МУЗГ-тай харилцаж тэдний улс төрийн арыг нь даах хэрэгцээг тодорхой хэлжээ. Товчхондоо, уул уурхайн компаниуд нь Канад улсаас АНУ, Их Британи, Япон, Авсгали, Герман зэрэг улстай нэгдэн МУЗГ-ыг уул уурхайн бизнесээс гадна байж, ил тод, урьдчилан таамаглалтай, хамгийн сайн туршлагад суурилсан, хуулийн дээдлэх хандлагаар зохицуулах ба Монголын байгалийн баялгаас хүртэх нөхцөлийг бүрдүүлэхэд шахаж ажиллахыг хүсчээ. Английн Элчин сайд эдээр санаагдэмжижээ.» [...] «АНУ-ын Түр хамаарагч» [тэмдэглэлүүд] «АНУ-ын ЗГнь бүххөрөнгө оруулагчдад зах зээлийн тууштай орчин бүрдүүлж, тогтвортой байлгах тал дээр МУЗГ-ыг тогтмол, байнга зоригжуулж байв гэв. Тэрбээр хөрөнгө оруулалт татах нь Монгол Улсын ЗГ-аас Оюу Толгойн зэс алтны уурхай зэрэг томоохон төслийн саналд хир нухацтай хандаж, цаг тухайд нь шийдвэр гаргах нь чухал үүрэг гүйцэтгэнэ гэж нэмж хэлэв.»

2008 оны 2 сар⁹⁹

Ил тод байдал, хууль дээдлэх засаглал зэрэг дээр дурдсан ойлголтууд буруу, эргэлзээтэй ойлголт биш боловч бизнесийн байгууллагууд, томоохон уул уурхайн ашиг сонирхол, хүчирхэг улс орнуудын хамссан Монгол Улсын Засгийн газрыг Оюу толгойн гэрээ хэлэлцээрт оруулах хүчин чармайлт нь Рио Тинто, Айвенхоу Майнзтай хийсэн хэлэлцээнд Монголын Засгийн газрын хэлэлцэх чадавх болон улс орныхоо эрх ашгийг хамгаалах чадварыг нь хязгаарласан байх талтай. Монгол Улс барууны санхүүгийн байгууллагууд ба улс орнуудад санхүүгийн өртэйгөөс гадна эдгээр олон улсын тоглогчид нь Монгол Улсын худалдааны ба бизнесийн түншийн нэр хүндэд нь нөлөөх чадвартай юм¹⁰⁰. ОТ-ны хөрөнгө оруулалтыг гэрээ хэлэлцээний Ажлын хэсгийн гишүүн асан хүний тайлбарласнаар «МУЗГ ба Рио Тинтогийн хоорондын харилцааг маш тэгш бус, бас тэнцвэргүй юм» гэжээ.

АНУ, Канад, Их Британи зэрэг улсуудын «зөөлөн» ба «хатуу» үхуулгаар МУЗГ нь уул уурхайн бодлогоо урсгалаар явуулах болсон нь Монгол Улсын ардчилсан замаар сонгогдсон төр нь хэрхэн гадаадын дипломат албаны нөлөөнд автдаг болохыг давхар харуулж байна. Мөн түүнчлэн эдгээр улсууд нь корпорацийн ашиг сонирхлыг ардчилсан үнэт зүйлсээс дээгүүр тавьдаг болохыг гэрчилж байна.

«ДТГ[АНУ-ын ЭСЯ] ба уул уурхайн компаниуд 2008 оны УИХ-ын ба 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн мөчлөгийн дараа зах зээлийн хандлагыг бий болгох үндэс суурийг бүрдүүлэхээр чимээгүй ажиллав.»¹⁰¹

2008 оны 3-р сар

99 2008-02-06 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html (2019-04-26).

100 Lander, 2020, x. 119.

101 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR118_a.html (2019-06-17).

2008 оны 1-р сарын өглөөний цайны уулзалтаар тохирсон Оюу Толгойн асуудлаар Монгол Улсад дипломат шахалт үзүүлэх төлөвлөгөө нь сонгуулийн дараах үймээн, дэлхийн санхүүгийн хямрал, түүхий эдийн үнэ уналттай давхцаж үр дүндээ хүрчээ. Оюу Толгойн гэрээ хэлэлцээ нурж байгаа мэт харагдаж, Монгол Улс Рио Тинто, Айвенхоу Майнзыг Хятадын буюу Оросын хөрөнгө оруулагчдаар орлуулах хувилбарыг судалж байв¹⁰², энэ үед АНУ-ын Элчин сайдын яам бусад хандивлагч орнуудтай гар нийлж хэлэлцээг ахиулахаар ажиллав. Тэд хамтдаа «МУЗГ нь өмнө нь гэрээ байгуулахаар тохиролцсон барууны компаниудтайгаа учраа олж маргааныг шийдвэрлэх нь Монгол Улсын ашиг сонирхолд нийцнэ гэсэн тод ба тууштай санаа» МУЗГ-т илгээв (2009).¹⁰³

3.3 Монгол Улсын эрх зүйн болон санхүүгийн тогтворгүй байдал ба өрнөдийн уул уурхайн ашиг сонирхол

Сүүлийн гуч орчим жилийн турш Монгол Улс санхүүгийн хүндрэлтэй үедээ Олон улсын валютын сан (ОУВС)- гаас зээл олгохыг удаа дараа хүсч байсан. Уул уурхайгаас хараат эдийн засаг нь түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгийгээс гадна өгөөжөө өгөх нь тодорхой бус эрсдэл ихтэй улмаас томоохон хөрөнгө оруулалт ба эрсдэл их авч ихээхэн өрөнд ордог.¹⁰⁴ Эдүгээ, МУ гадаад өрийн хэмжээгээр «маш хүнд» гэж үзэх 7 орны нэг болсон байна.¹⁰⁵ ОУВС-нд 1991 онд гишүүнээр элссэнээс нь хойш тус улсад зургаан зээлийн багцыг олгожээ. 2016 онд зургаа дахь удаагаа олгосон ийм зээл¹⁰⁶ нь Монголын гадаад өрийг ДНБ -ээс нь хоёр дахин илүү 11.2 тэрбум ам. доллар¹⁰⁷ хүргэв. Энэ зээлийн нөхцлөл нь төсвийн шинэчлэл¹⁰⁸ хийж, цалин хөлсийг царцаах, хувь хүний орлогын албан татварын нэмэгдүүлэх¹⁰⁹ зэрэг бүс чангалах арга хэмжээ авахыг шаарджээ.

102 2008-02-06 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html, 2009, 26 augustus: https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-04-26).

103 2008-03-19 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-04-26).

104 Бүрэн эхээр UNCTAD (2019) at https://unctad.org/meetings/en/SessionalDocuments/cimem2d46_en.pdf (2019-10-28).

105 Global Sovereign Debt Monitor (2019): pg 4. <https://erlassjahr.de/wordpress/wp-content/uploads/2019/05/Global-Sovereign-Debt-Monitor-2019.pdf> (28 october 2019).

106 International Monetary Fundwebsite, 2017, at <https://www.imf.org/en/News/Articles/2017/05/24/17193-imf-executive-board-approves-financial-arrangement-for-mongolia>, see also Bloomberg, 2017, at <https://www.bloomberg.com/news/articles/2017-02-19/imf-to-loan-mongolia-440-million-as-part-of-5-5b-bailout> (2017-06-12).


107 Mongol bank, Mongolia's Gross External Debt Position at https://www.mongolbank.mn/eng/liststatistic.aspx?id=4_3; Financial Times, Mongolia: living from loan to loan, September 12, 2016 at <https://www.ft.com/content/4055d944-78cd-11e6-a0c6-39e2633162d5>; Focus Economics at <https://www.focus-economics.com/country-indicator/mongolia/external-debt>; <https://www.gfmag.com/global-data/country-data/mongolia-gdp-country-report> (2017-08).

108 For a discussion on IMF conditionality, and for Mongolia in particular, see Brunswijck, G. (2018) Unhealthy Conditions, <https://eurodad.org/files/pdf/1546978.pdf> (2018-12-17).

109 Bloomberg, , 19 April 2017, at <https://www.bloomberg.com/news/articles/2017-04-19/mongolia-clears-hurdles-needed-for-5-5-billion-imf-led-bailout> (2017-08-08).

Монгол Улсад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт ба гадаад өр

МУ-ын гадаад өр сая ам.доллаар



Зээлийн багц нь үе үе МУЗГ-ын хувьд «амь залгуулагч» болдог тул ОУВС нь Монголд туйлын хүчирхэг тоглогч болох нь мадаггүй. ОУВС-нд саналын эрхийг тус санд оруулсан хөрөнгөнөөс хамааран хуваарилна. ОУВС-гийн нийт саналын эрхийн 16.5 хувийг дангаараа эзлэх АНУ нь ОУВС-д хамгийн том хувь нийлүүлэгч¹¹⁰ бөгөөд де-факто хориг тавих эрхтэй. Монгол Улсын ОУВС-аас хараат байдал нь улмаар АНУ-ын нөлөөнд маш өртөмтгий болохыг илтгэнэ.

Элчин сайдын яамны цахилгаан мэдээнүүд нь Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг ОУВС болон АНУ-ын тусламжтай хэрхэн уялдуулж байгааг харуулна:

«Хураангуй. [2009] оны 4-р сарын 2-ны өдөр, Хятад, Монголыг хариуцсан [Төрийн нарийн бичгийн даргын туслах] [...] Улаанбаатарт Монгол Улсын Гадаад хэргийн сайд Батболдтойуулзав. [...] Батболд Монгол Улс ОУВС-тай саяхан байгуулсан Стэнд-бай гэрээнд (SBA) сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж, МУЗГ нь SBA -тэй холбоотой [АНУ-ын Засгийн газраас] төсвийн туслалцаа хүсч байгааг хэллээ. [Монгол Улсын Гадаад хэргийн сайд] АНУ-тай хийсэн Ил тод байдлын хэлэлцээр (ИТБХ) нь манай хоёр улсын худалдааны харилцааг урагшлуулах хэрэгсэл мөн бөгөөд ЗГ нь Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг (ОТХОГ) УИХ-д 4 сарын 6-нд дахин оруулж батлуулах чин эрмэлзэлтэй байгаа гэж мэдэгдэв.»¹¹¹

2009

110 The second largest share of the vote is Japan with 6.15%, followed by China with 6.09%. <https://www.imf.org/external/np/sec/memdir/members.aspx#U> (2019-04-29).

111 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR94_a.html, retrieved, (2019-04-26).

Дээрх ишлэл нь АНУ-ын албан тушаалтнууд ОУВС-гийн тусламж, ОТХОГ-г Монголын парламентаар батлуулах асуудлыг холбож байгааг харуулж байна. Энд тэмдэглэх чухал зүйл бол АНУ нь ОУВС, Дэлхийн банкинд¹¹² хориг тавих эрхтэй гэдэг нь эдгээр ОУСБ-уудын Монгол Улсыг санхүүгийн хувьд дэмжихтэй холбоотой шийдвэр гаргахад мөн л голлох үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг. Цаашилбал, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдал нь ОУВС-аас ихээхэн хамааралтай. Энэ хамаарлыг 2017 оны 2-р сард Монгол Улсын Засгийн газар санхүүгийн бас нэгэн хямралаас гарах ээлжит зээлийн багцыг¹¹³ ОУВС-гаас авах үйл явц дахин харуулав. Тухайн үед УИХ нь гадаадын үндэстэн дамнасан компанийн гадаад төлбөр тооцоог Монголын арилжааны банкуудаар дамжуулан шилжүүлж байх тухай банкны хууль тогтоомж дээр ажиллаж байв. Дөрөвдүгээр сард зарласан уг хууль нь улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, мөн түүнчлэн Монголын банкны салбарыг бэхжүүлэх зорилготой байв. АН-аас сонгогдсон Ц. Элбэгдорж ерөнхийлөгч байхдаа «Монголын бусад компаниудтай адил Рио Тинто компани нь Оюутолгойн санхүүгийн бүх мөнгөний гүйлгээг нь Монголын банкуудаар дамжуулж байх ёстой» гэж олон нийтэд 2013 зарласнаас хойш компанийн санхүүгийн урсгалуудыг Монголын банкуудаар дамжуулах нь улс төрийн сэдэв болсон юм. Тэрээр Тэд Монголд ажиллаж байгаа л бол улс орны хөгжилд хувь нэмрээ оруулах ёстой.¹¹⁴ гэжээ.

Банкны шинэ хуультай холбогдуулан 2017 оны 4-р сард Рио Тинто ОУВС-д эсэргүүцсэн гомдол гаргасан тухай мэдээлэл бий¹¹⁵. ОУВС удалгүй зээлийн багцаа зогсоов.¹¹⁶ Тухайн үед эрх баригч Монгол ардын намын ахмад гишүүн дараахь зүйлийг хэлэв. Үүнд:

«ОУВС-гийн буцалтгүй тусламжгүйгээр Монгол Улсурагшлах боломжгүй... Эдийн засагхүнд байгаа тул Монгол Улс эхлээд тусламжийг авах ёстой. Үүний дараа бид гадаадын хөрөнгө оруулалт Монголын банкаар дамжих эсэх талаар ярилцах болн.»¹¹⁷

112 On the IMF veto: <https://fas.org/sgp/crs/misc/IF10676.pdf>, and the World Bank veto: <https://www.worldbank.org/en/country/unitedstates/overview> (2019-04-26).

113 <https://www.imf.org/en/News/Articles/2017/02/19/PR1754-Mongolia-IMF-Reaches-Staff-Level-Agreement-on-3Yr-EFF> (2019-10-28).

114 <https://www.mining.com/president-time-has-come-for-mongolian-government-to-take-oyu-tolgoi-matters-into-its-own-hands-94654/> (2018-12-17).

115 Bayartsogt, K. May 2, 2017, <https://asia.nikkei.com/Politics/Mongolia-to-revise-new-law-after-IMF-postpones-bailout2> (2019-04-26).

116 Hornby, L. May, 2, 2017, IMF delays approval for Mongolia package over forex clause, <https://www.ft.com/content/07ed751a-2f0e-11e7-9555-23ef563ecf9a>, Edwards, T. May 2., 2017, <https://www.reuters.com/article/mongolia-economy/update-1-imf-delays-mongolia-bailout-due-to-banking-requirements-for-foreign-firms-idUSL4N1I41PL> (2018-12-17).

117 Bayartsogt, K. May 2, 2017, <https://asia.nikkei.com/Politics/Mongolia-to-revise-new-law-after-IMF-postpones-bailout2> (2019-04-26).

Гуравхан хоногийн дотор Монгол Улсын хууль тогтоох байгууллага уг хуулийг хүчингүй болгосон.¹¹⁸ 2017 оны 5-р сарын 24-ний өдөр ОУВС 425 сая ам.долларын Өргөтгөсөн хөрөнгийн зээлийг 3 жилийн хугацаанд олгохоор батлав¹¹⁹. Энэхүү зээл нь ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Япон, Хятад улсаас нийт 5,5 тэрбум ам.долларын санхүүжилтийн багцын нэг хэсэг юм. Рио Тинто компани Монгол Улсын хуулийг эсэргүүцэн ОУВС-гийн зээл олголтыг зогсооход нөлөөлөв. ОУВС-ийн зээл орж ирэхгүйн дарамт нь хууль тогтоогчдыг өөрсдийн шийдвэрийг хүчингүй болгоход хүргэв. Энэ нь нэгдүгээрт Монголоос урсан гарах баялгийг тогтоох ардчиллын үйл явцын эрмэлзлийг корпорацийн хүчээр хэрхэн бусниулж байгаа болон хоёрдугаарт ОТХОГ нь монголын ард түмэнд ашиггүйг харуулж байгаа юм.

АНУ-ын Төрийн департамент ба ОУСК-ийн Хөрөнгө оруулалтын орчны тухай 2018, 2019 оны тайлангуудад Монгол Улсын зах зээлд ээлтэй орчин бүрдүүлэх олон улсын хүлээлтэд нийцүүлэх шахалтын нотолгоо юм¹²⁰. Жишээлбэл, АНУ-ын Төрийн Департаментын Монгол дахь Хөрөнгө Оруулалтын Мэдэгдэлд ОТХОГ-ээг эргэн харж болзошгүй байгааг буруушаасан атлаа нэг амьсгаагаар Монголын зах зээл элдэв хаалтаас чөлөөтэй, хөрөнгө оруулагчдад цөөхөн бодитой хязгаарлалт нүүрлэх бөгөөд ихэвчлэн чөлөөтэй зах зээлийн нөхцөл эдлэнэ¹²¹ гэж. МУ-ын гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хараат ба өрийн дарамттай хосолсон байдлыг нь ОУСК ба АНУ ашиглан эрх зүйн шинэчлэлд юуг хууль ёсны гэж зөвшөөрөх мэдэл бүхий шахалт нь Монголын ардчилсан институциудад эрээ цээргүй нөлөөлснийг харуулж байна.

Энэхүү хүчний динамик нь Рио Тинтотой хэлцэл хийх МУ-ын орон зай ямар бол гэх санаа зовнил болон ОУСБ болон АНУ мэт донор орнуудын дэмжлэгтэй корпорациудын өмнө Монгол Улсын эрх ашгийг хамгаалах чадвар нь хэр бол гэх асуулт ч төрж байгаа юм.

118 Edwards, T. May 5, 2017, <https://www.reuters.com/article/us-mongolia-imf/mongolia-annuls-forex-regulation-to-pave-way-for-imf-bailout-idUSKBN1810TF> (2018-12-17).

119 IMF website, 2017, <https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2017/05/31/Mongolia-2017-Article-IV-Consultation-and-Request-for-an-Extended-Arrangement-Under-the-44954> (2018-12-17).

120 Lander (2020, 233) Дэлхийн банкны нэвтрүүлдэг «хөрөнгө оруулалтын эрсдлийн үзүүлэлт» хэмээх нь хөгжлийн бодлогоо тодорхойлох улстөрийн оройн зайд хэрхэн нөлөөлөх тухай Perry-Kessaris, A. (2011) "Prepare Your Indicators: Economic Imperialism on the Shores of Law and Development" International Journal of Law in Context 7 (4): 401-421.

121 АНУ-ын Төрийн Департаментын ишлэл Lander 2020: 233.

3.4 Улс төрийн хонжоо юу? эсвэл Монголын хувь заяа юу?

Энэхүү цахилгаан мэдээнүүдэд АНУ, ОУВС-гаас корпорацийн ашиг сонирхлыг дипломат аргаар түрж байгаа жишээ нь МУ-ын өөрийн хөгжлийн чиг хандлагыг шийдвэрлэх маневрын орон зайг дэлхийн улс төр, эдийн засгийн нөлөөгөөр алдагдуулж байгааг харуулж байна. Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний үеэр Монголын Засгийн газар уг гэрээг Монголын ард түмэн хүлээж авахуйц болгохын төлөө тэмцэж байв.

Цахилгаан мэдээний агуулгаас харахад хэлэлцээрийн үеэр дөрвөн гол асуудалд анхаарч байж. Үүнд:

1. Уурхай дахь Монгол улсын эзэмших хувь 34% -аас 51% хооронд байх. Энэ хувийг (Рио Тинто-аас авсан зээлээр) төлж өмчлөх үү?, эсвэл Монгол улсын баялгыг эзний бүрэн эрхийн хувь байх уу?;
2. Оюутолгойд Хятад улсаас эрчим хүч импортлох бус өөрийн (Таван толгойн) эрчим хүчээр хангах асуудалд ач холбогдол өгч байж;
3. Монголд үнэ цэнээ авч үлдэх асуудал, татвараар, нэмүү өртөг үйлдвэрлэх (хайлуулах үйлдвэр байгуулах) эсвэл бусад үндэсний арилжааны үйлчилгээ (банкны)-ээр г.м.
4. Энэхүү гэрээ нь Монгол Улсын баялгийн үнэ цэнийг алдагдуулаагүй гэдгийг монгол хүмүүст итгүүлэх.

ОТХОГ-ний яриа хэлэлцээ нь ширүүн, маргаантай байсан. Засгийн газар анх 2004 онд Ерөнхий сайд Энхбаяр МАХН)- ын удирдлага дор хэлэлцээг түргэн эхлүүлсэн боловч сонгуулийн дараа уул уурхайн үйл ажиллагаанд дургүйцсэн нийгмийн тогтворгүй байдалтай холбоотойгоор шүүмжлэлтэй хандах болов¹²². Улсынхаа байгалийн баялгийг гадныханд өгч буй нь нийгмийг бухимдуулсны дараа Засгийн газар нь 2006 онд гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг нэвтрүүлжээ. Төсөл нь нийгмийн эсэргүүцэлтэй тулгарсаар¹²³ байсан нь Монголын улс төрчид улсдаа илүү тохиромжтой гэж үзсэн тохироог удаа дараа шаардахад хүргэсэн бололтой. 2007 онд Ерөнхийлөгч болсон Энхбаяр уурхайд Монгол улс 51 хувийн эзэмшилтэй болгохыг уриалав. 2008 оны сонгуулийн үеэр улс төрийн хоёр том нам хоёул энэ шаардлагыг тавив.¹²⁴ АНУ-ын ЭСЯ-ны үзлээр:

«ЗГ нь уг асуудлыг [51%] гадаадын хөрөнгө оруулагчдад тулгасан гэх дүр эсгэхгүй бол улс төрийн өрсөлдөгчиддөө «улсаа худалдлаа» гэж уруулах эрсдэлд өртнө.»¹²⁵
2007

122 http://www.civicus.org/media/CSI_Mongolia_Executive_Summary.pdf (2019-09-17).

123 <https://www.transrivers.org/documents/rivers-and-mining/the-short-history-of-the-law-with-long-name/> (2018-12-11).

124 2007 2 сар, https://wikileaks.org/plusd/cables/07ULAANBAATAR119_a.html; 2008-12-01 https://wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR521_a.html; 2008-02-06 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html; https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR227_a.html; 2008-03-19 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR118_a.html; https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR201_a.html; 2009-03-03 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR87_a.html (2019-04-26).

125 https://wikileaks.org/plusd/cables/07ULAANBAATAR119_a.html (2019-04-26).

АНУ-ын ЭСЯ-ны хүрээнд Монголын төрийнхэн, хэвлэл мэдээллийнхэн, Рио Тинто ч Оюу Толгойг Монголын ард түмэнд хэт ухуулсны дүнд «*тэр даруй асар өндөр ногдол ашиг өгнө*»¹²⁶ гэсэн хүлээлт үүссэн гэж үзэж Рио Тинто ч, АНУ-ын Элчин сайдын яамны ажилтнууд ч Оюу Толгой компаниас Монголд ноогдох ашиг нь эхлээд төслийнхөө 34 хувийг санхүүжүүлэхийн тулд авсан зээлийг төлөхөд зориулагдах учир¹²⁷ Монголын Засгийн газарт олон жилийн туршид ногдол ашиг төлөхгүй гэдгийг мэдэж байсан. Энэхүү ойлголтын зөрүүг далдлахын тулд Рио Тинто ОТХОГ-нд гарын үсэг зурсны дараа Засгийн газарт 250 сая долларын зээл олгохыг зөвшөөрөв. Элчин сайдын яамны ажилтнууд энэхүү тохироог дараах байдлаар тайлбарлав: «*Хэдийгээр энэ нь зээлийн анхны транш боловч бэлэн мөнгөний хомсдолтой [Монголын Засгийн газар] нь ойрын ирээдүйд халаасны мөнгө олохыг хүсч буй Монгол Улсын иргэдэд нэмүү орлого мэтээр зарлав.*»¹²⁸

«Луувангаар хуурах мэт, хэрвээ ямар нэгэн шийдэлд хүрээд байх юм бол Рио Тинто нь ЗГ-т урьдчилгааг өгөөд байхад бэлэн гэдгээ мэдэгдэв... ЗГ, УИХ болон намууд сонгогчдод уул уурхайгаас олох шанг аль хэдийнэ амласан бөгөөд аливаа урьдчилгаа нь сонгуулийн амлалтыг биелүүлэхэд шаардагдаж байв (энэ маргаанд оролцсон хэн бүхэнд ойлгомжтой).»¹²⁹

Дээр дурдсан урьдчилгаа төлбөр гэгч нь үнэндээ ОТХОГ-г олон нийтэд борлуулах зориулалтаар Монгол Улсын ЗГ авч ашигласан 250 сая ам. долларын зээл билээ. АНУ-ын албан тушаалтнуудын хэвлэл мэдээллийн эх сурвалжууд болон хувь жишээ ярианд тулгуурлан хийсэн шинжилгэнд Монголын олон нийт энэ 250 сая ам.долларыг ОТ-н Монголд үр өгөөж өгөхийн нотолгоо гэж харж байна хэмээн дүгнэжээ. Хэрэг дээр МУЗГ-аас Оюу Толгойн 34 хувийг санхүүжүүлэхийн тулд авахаас өөр аргагүй болсон хэдэн тэрбум долларын зээлийн хамт уг зээлийг бүхэлд нь бүрэн төлөх ёстой өр юм.¹³⁰

*«Эцэст нь гэрээнд албан ёсоор гарын үсэг зурахаас өмнө авто зам, ус, гэнэтийн ашгийн албан татвар, аж ахуйн нэгжийн татвар гэсэн дөрвөн хуульд өөрчлөлт оруулахаар болсон. УИХэдгээр нэмэлт өөрчлөлтийг наймдугаар сарын 25-ны шөнө дуусгаж, ЗГ нь ирэх долоо хоногт гэрээнд гарын үсэг зурахаар төлөвлөж байна. Үүний дараа 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөр болох эхний 100 сая ам.долларыг авах болно.»*¹³¹

126 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR315_a.html (2019-04-26).

127 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR315_a.html (2019-04-26).

128 https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR315_a.html (2019-04-26).

129 2008, March 19, https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR118_a.html (2019-04-26).

130 2009-10-29, https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR315_a.html (2019-04-26).

131 2009, Augustus 26, https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR244_a.html (2019-04-26).

Оюу Толгойд эзэмших хувийг нэмэгдүүлэх хүсэл 2011 онд эргэж ирэв.¹³² Хэлэлцээрийн явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байсан Монголын улстөрчдийг дурдвал Энхбаяр (эхлэх үед Ерөнхий сайд, сүүлд нь Ерөнхийлөгч), З.Энхболд, С.Баярцогт (ОТ гарын үсэг зурах үед Сангийн сайд), Д.Зоригт (Эрдэс баялаг, эрчим хүчний сайд) дараа нь С.Баярбат, С. Баяр (ОТХОГ-г гарын үсэг зурах үед Ерөнхий сайд) зэрэг болно.¹³³ Эрдэнэс Монголын захирал Б. Бямбасайханыг МУ-ын ТӨҮГ-ыг төлөөлөх гол хэлэлцээг хийсэн хэмээн сайшааж байжээ. Бямбасайхан нь өмнө нь Хойт Америк Монголын Бизнес Зөвлөлийн ерөнхийлөгч бөгөөд Дубайн гэрээ байгуулсны дараагаар ОТ-н ТУЗ-д томилогдсон байдаг.¹³⁴

2018 онд МУ-ын Авлигатай тэмцэх газар ОТХОГ-д гарын үсэг зурах үед Сангийн сайдаар ажиллаж байсан Баярцогт, Б.Бямбасайхан («Эрдэнэс Монгол» компанийн гүйцэтгэх захирал\ Дубайн гэрээ) болон Ариунсан (Таварын ерөнхий газар\2015) нарыг баривчилжээ.¹³⁵ Оюутолгойн гэрээнд гарын үсэг зурах үед Ерөнхий сайд байсан Санжийн Баяр, 2015 оны Дубайн гэрээнд гарын үсэг зурах үед Ерөнхий сайд байсан Чимэдийн Сайханбилэг нар мөн баривчлагдав.¹³⁶ Бүгдийг нь сулласан боловч Баярцогтыг 2019 оны 1-р сард дахин баривчилжээ.¹³⁷

132 Bouw, Branda, September 25, 2011: Politicians seek larger stake of Oyu Tolgoi project; Ivanhoe says agreement is binding: "A group of 20 parliamentarians has submitted a petition to the Mongolian government asking have its stake in Oyu Tolgoi increased to 50 per cent from the current 34 per cent." <https://www.theglobeandmail.com/report-on-business/international-business/mongolia-wants-bigger-stake-in-massive-ivanhoe-copper-mine/article595583/> (2019-04-18).

133 Myadar & Jackson (2019).

134 Lander, 2020:136 ишлэл 34.

135 Daariimaa Batnasan, April 5, 2018, <https://theubposts.com/s-bayartsogt-b-byambasaikhan-and-b-ariunsan-to-be-detained-for-30-days-over-oyu-tolgoi-deal-allegations/> (2019-04-18).

136 Davaasharav M. & D. Stanway, 2015-04-11, <https://www.reuters.com/article/mongolia-oyutolgoi/mongolia-anti-graft-agency-arrests-two-prime-ministers-amid-mine-probe-idUSL3N1RO3OP>, Jamasmie, C. 2018-03-18, <https://www.mining.com/anti-corruption-body-asks-rio-oyu-tolgoi-related-info/>, Jamasmie, C. May 22, 2018, <http://www.mining.com/rio-tinto-says-investors-take-stance-oyu-tolgoi-test-case/> (2019-04-22).

137 Davaasharav M. & B. Lewis, 2019-01-19, <https://www.reuters.com/article/us-mining-riotinto-mongolia/mongolia-over-seas-investigators-probe-oyu-tolgoi-corruption-claims-as-ex-minister-re-arrested-idUSKCN1PN0OY> (2019-04-18).

4 Хэн Оюу Толгойгоос хожиж байна вэ?

SOMO-ийн 2018 оны «Уул уурхайн татвар» тайлан илтгэлд Рио Тинто болон Оюу Толгойн бусад хөрөнгө оруулагчид МУЗГ-тай байгуулсан хэлэлцээрийн дагуу татварын хөнгөлөлт эдэлж, мөн Нидерланд, Люксембург дахь шуудангийн хайрцгийн компаниудыг ашиглан татвараас зайлсхийх схемээр татвараа бууруулж байгаа талаар мэдээлсэн. Уг тайланд Канадын Засгийн газар Рио Тинтогийн татвараас зайлсхийх мэхнээс болж 470 сая ам.долларын татварын орлого алдсан болон Засгийн газар нь Оюу Толгойд олгосон татварын хөнгөлөлтүүдээс болж Монгол Улс 230 орчим сая ам.долларын татварын орлого алдсныг харуулсан.

4.1 Монгол Улсын татварын алдагдлууд

Оюу Толгойн татварын практикт дүн шинжилгээ хийх явцад SOMO нь 2009 оны ОТХОГ-нд тусгагдсан санхүүгийн тогтворжуулалтын тухай гэгч заалтыг олж харсан. Энэхүү заалтын дагуу Оюу Толгойд татвар ногдуулахдаа зөвхөн ОТХОГ-нд гарын үсэг зурах үеийн 2009 онд мөрдөгдөж байсан татварын хууль, татварын гэрээг хэрэглэх хязгаарыг МУ-ын татварын албаныханд тавьсан байдаг.

Санхүүгийн тогтворжуулалтын заалтыг хэрэглэх зөвлөмждөө ЭЗХАХБ нь улс орнууд ийм тогтворжуулах заалтуудын үргэлжлэх хугацаа, хамрах хүрээг хязгаарлах талаар үргэлж бодолцож байхаар тусгажээ.¹³⁸ Цаашилбал, ЭЗХАХБ нь санхүүгийн тогтворжуулалтаас болзошгүй орлогын алдагдлыг нөхөхийн тулд даатгалын шимтгэл төлүүлж байхыг улс орнуудад зөвлөдөг байна. Оюу Толгойн хувьд эдгээр хамгаалалтыг огт хэрэгжүүлээгүй байдаг.

2013 онд ОУВС-гийн нэгэн тайланд Монгол улсын давхар татварын дөрвөн гэрээ нь татвараас зайлсхийх боломж олгох магадлалтай гэж эргэн харахыг зөвлөж байсан.¹³⁹ ОУВС-ийн тайлан гарсны дараахан Засгийн газар дөрвөн гэрээг бүхэлд нь цуцласны хоёр нь Нидерланд, Люксембургтэй байгуулсан гэрээ байсан. ОТХОГ-ний тогтворжуулалтын заалтууд нь бүх татварын хууль тогтоомж, гэрээг 2009 оны түвшинд царцаасан тул эдгээр давхар татварын гэрээний цуцлалт нь Оюу Толгойд нөлөөлөөгүй болно. Иймд Оюу Толгойн санхүүгийн тогтвортой байдлын гэрээний заалт нь Рио Тинто болон бусад хөрөнгө оруулагчдад цуцлагдсан татварын гэрээнд тусгагдсан татварын бага түвшинг үргэлжлүүлэн ашиглах боломжийг олгосоор байна. Уул уурхайн татварын талаарх илтгэлдээ SOMO нь санхүүгийн тогтворжилтийн энэ заалт нь ОТ-той холбоотой хэсэгт

138 OECD website, 2019, <https://www.oecd.org/tax/beps/hidden-cost-of-tax-incentives-in-mining-draft-toolkit-oecd-igf.pdf> (September 22, 2019).

139 IMF website, 2012, <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2012/cr12306.pdf> (September 22, 2019).

Монгол Улсын санхүү татварыг зохицуулах төрийн бүрэн эрхийг алдагдуулсан гэж үзсэн болно. Тогтворжуулалтын эцсийн хугацааг заагаагүй нь Монгол Улс хууль тогтоомжийг яаж ч өөрчилсөн болоод ядмаг боловсруулсан татварын гэрээний алдааг засч залруулаад ч, Оюу Толгой компанийн хөрөнгө оруулагчдын ашиглаж буй аливаа татварын нүүхийг хааж чадахгүй гэсэн үг юм.¹⁴⁰ Үүгээр барахгүй Монгол Улс татварын хэмжээг 2009 оны түвшнээс доогуур тогтоох хууль тогтоомж гаргасан тохиолдолд Оюу Толгойн компанийн хөрөнгө оруулагчид тэр доод түвшинг ашиглахаар сонгож болно гэж тохиржээ.¹⁴¹ Иймээс Монгол Улс Оюу Толгойгоос юу хүлээх вэ?

SOMO-ийн Уул уурхайн татварын тайлан илтгэлийн хариуд бусад хэд хэдэн хэвлэл Оюу Толгойн татварын тохиролцоонуудыг хамгаалсан. Тайланд өгсөн сонирхолтой нэгэн тайлбарт Монгол Улсын татварын орлого санхүүгийн тогтворжуулалтын гэрээнээс болж үлэмж буурсан ч Оюу Толгойн гэрээ бүхэлдээ «Монгол Улсын хувьд сайн» зүйл болов гэжээ. Татвар нь Оюу Толгой шиг мега төслийг зохицуулах ганц тохиролцоо гэвэл тийм байж болно. Тэгвэл энэ нь нэг асуултыг сөхөж байна: Оюу Толгойгоос хэн хожиж байна вэ?

Уул уурхайн тохироог хэлэлцэж буй компаниуд болон засгийн газрууд тохирооноос үүсч болзошгүй санхүүгийн үр дагаврыг тооцоолохыг хичээдэг. Үүний тулд тэд гарах зардал, олох олз хэрхэн хуваарилагдахыг таамаглах санхүүгийн нарийн төвөгтэй загваруудыг ашигладаг. Уурхайг барьж байгуулах, ашиглалтад оруулах зардал, төслийн санхүүжилтийг хангахад ямар зардал шаардагдах вэ? гэсэн тооцоог гаргадаг. Ашигт малтмалын үнэ тогтмол гэж үзвэл уурхайгаас хичнээн орлого олох боломжтой, эдгээр орлогыг компани болон төр хоёрын хооронд хуваарилах (хувь эзэмших тохиолдолд), уурхайн орлогоос авах татварын хэмжээ хэд байх гэх мэтчилэн тооцоог мөн гаргадаг.

Ийм байдлаар санхүүгийн загварууд нь уул уурхайн төслийн өртөг/өгөөжийн шинжилгээ хийдэг. Гэхдээ ийм загварууд нь улсын зардал, үр ашгийг тооцохдоо олборлоогүй нөөцийн боломжит үнэ цэнийг оруулж тооцдоггүй болохыг анхаарах нь чухал юм. Олборлоогүй ашигт малтмалын үнэ цэнийг үнэлэхэд хэцүү тул энэ нь ойлгомжтой байж магад. Гэсэн хэдий ч бас анзаарвал зохих зүйл нь, уул уурхайн хэлэлцээрт орж буй засгийн газар нь эрдэс баялгийн нөөцөө бүхэлд нь тавьж, хэлэлцээрийн дүнд түүнийгээ «алддаг» хөрөнгө юм.

Монголын засгийн газрын эх сурвалжийн мэдээлснээр – Оюу Толгойн гэрээ нь ихээхэн маргаан дагуулсан тул тэдний хэн нь ч ил гарахыг хүсээгүй – Монгол Улсын Засгийн газар 2009 онд Голдман Сакс компанийг уурхайн санхүүгийн загварыг бий болгохоор гэрээлсэн гэдэг.¹⁴² Энэхүү загвар нь нийтлэгдээгүй ч Оюу Толгойгоос олсон ашгийг Рио Тинто болон бусад хөрөнгө оруулагчид 47 хувь, Монголын Засгийн газарт 53 хувийг хүртэх гэж

140 Technically, Mongolia will regain its fiscal sovereignty with regard to Oyu Tolgoi when the Investment Agreement's end date is past. However, as the Investment Agreement will be in effect for an initial 30 year period, with an optional 20 year extension Rio Tinto can choose to take, this will likely come too late. See also OT website, 2019, http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_EN.pdf see articles 1.1. and 15.11. (September 22, 2019).

141 OT website, 2019, http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_EN.pdf see article 2.24.2. (September 22, 2019).

142 Голдман Саксын үзүүлсэн туслалцааны тухай мөн энд: Ш. Адъяамаа, April 11, 2014, <https://news.mn/en/140219/> (2019-09-22).

тооцоолжээ.¹⁴³ 2016 онд Open Oil зөвлөх компани өөр загвар гаргасан бөгөөд түүгээр МУЗГ Оюу Толгой ашгийн 57 орчим хувийг авах, үлдсэн 43% нь Рио Тинто болон бусад хөрөнгө оруулагчдад очих боломжтойг нарийвчлан гаргажээ.¹⁴⁴

Гэвч Монголын засгийн газрын эх сурвалжууд эдгээр загваруудын аль нь ч бодитой биш гэж үзэж байгаа бөгөөд Засгийн газар Оюу Толгойгоос авах ашиг нь мэдэгдэхүйц буурах магадлалтай аж. Үүний гол шалтгаан нь Оюу Толгойн тогтворжуулалтын гэрээний заалтын нөлөөллийг эдгээр загваруудад тооцоогүй болно. Тодруулбал, Тогтвортой байдлын гэрээний заалт нь одоо хүчин төгөлдөр бус болсон Монгол Улс-Нидерланд ба Монгол Улс-Люксембургтэй урьд өмнө байсан давхар татварын гэрээг үргэлжлүүлэн ашиглах боломжийг Оюу Толгойн уурхайн хөрөнгө оруулагчдад олгосоор байгаа юм. Энэ нь Оюу Толгой компаниас¹⁴⁵ гадаадад хийх бүх төлбөрт¹⁴⁶ төлөх суутган татварыг бууруулж байгаа. Олон нийтэд нээлттэй Open Oil-ын санхүүгийн загварыг ашиглан эдгээр татварын доод хэмжээг суулгаж тооцоход Монгол Улсын Засгийн газрын Оюу Толгойгоос авах орлого 57% -иас 45% хүртэл буурч байна.¹⁴⁷

Open Oil-ын загварт Оюу Толгой компанийн Монголд өгөх өгөөжийн 45 хувь нь НӨАТ, роялти, орлогын албан татвар, ногдол ашгаас бүрдэж байгаа юм. Рио Тинтогийн мэдээлж байгаагаар 2010-2018 оны хооронд Оюу Толгой компани Монгол Улсын Засгийн газарт¹⁴⁸ 2.3 тэрбум ам.доллар төлсөн гэх ба энэ нь НӨАТ болон нөөц ашигласны төлбөрөөс бүрдсэн байж болзошгүй юм. Open Oil -ын загвар нь 2031 оноос эхлэн Оюу Толгой компани орлогын албан татвар, ноогдол ашгийг Засгийн газарт төлж эхэлнэ гэж тооцоолжээ. 2031 оноос уурхайн ашиглалтын хугацаа дуусах 2055 он хүртэлх хугацаанд төлөх ноогдол ашгийг өнөөгийн үнээр 200 сая доллар орчим гэж Open Oil тооцоолжээ.¹⁴⁹ Оюу Толгойгоос авах ногдол ашгийн тухайд Оюу Толгойн ТУЗ-ын гишүүн ба Эрдэнэс Монгол ХХК-ийн ахлах эдийн засагч Чулуунцэрэнгийн Отгочулуу¹⁵⁰ 2013 онд Уул уурхайн яамны Стратегийн бодлогын газрын захирал байхдаа дараахь зүйлийг хэлж байв:

143 2015 ОТДУББСТ-ндөө Рио Тинто ОТ-н ашгаас Монголын талд татвар, роялти ба ноогдол ашгаас бүрдэх 53% ноогдоно хэмээн дахин баталгаажуулсан байдаг. http://ot.mn/media/ot/content/Agreements/2015-05-18_OTUMDAFP.pdf, p.3, (201909-22).

144 OpenOil website, <https://openoil.net/portfolio/oyu-tolgoi-model-and-narrative-report/> (2019-09-22).

145 Оюу Толгойн татвар зувчуулалтын схемийн талаар эндээс: SOMO's 2018 publication <https://www.somo.nl/riotinto-taxschemes-mongolia>.

146 Ийм төлбөрүүд зээлийн хүү, роялти, ноогдол ашига ба менежмент-техникийн төлөөс мэт хэлбэртэй байж болдог.

147 Үүнийг жишээлбэл хүүний суутган татварыг 20% -оос 6.6% болгож бууруулах, ноогдол ашгийн суутганыг 20% -оос 0%, болон менежментийн зардлын суутган татварыг 20%-оос 5% болгож бууруулах. Эдгээр суутган татварын хэмжээ нь МУ ба Нидерландын хооронд байгуулсан одоо цуцлагдсан гэрээнд сууж өгсөн байдаг. <http://www.itc-leiden.nl/UserFiles/Documents/Mongolia%20ENG.pdf> (2019-09-22).

148 https://www.riotinto.com/search#main-search_q=taxes%20paid&main-search_e=0 (2019-02-22).

149 OpenOil calculate this present value of the dividends, using a Net Present Value with a 10% discount rate. OpenOil, Oyu Tolgoi Project Fiscal Model Narrative Report.

150 OT website, <https://www.ot.mn/otgochuluu-chuluuntseren/> (2017-12-08).

«Монголын засгийн газар уурхайгаас гарах бүх зардлын 34 хувийг өөрөө хариуцах үүрэг хүлээсэн тул зардал өсөх тусам улсаас Рио Тинтод төлөх өр нь өснө. Өрийг хэдэн арван жил төлнө. Уурхайн анхны ногдол ашгийг 2019 онд үзнэ гэж бид бодож байсан. Гэвч ашиг хүртэх нь 20-30 жилийн цаана болж байна.»¹⁵¹

Оюу Толгой ордын 34 хувийг эзэмших – үүнээс олох ноогдол ашгийг хүртэх – нь Рио Тинто компанитай хийх хэлэлцээнд МУЗГ-ын хувьд чухал нөхцөл байсан.¹⁵² Монгол Улс уурхайд хөрөнгө оруулах санхүүгийн боломж байгаагүй тул Засгийн газар Рио Тинтогоос зээл авч, дараа нь ногдол ашгаасаа зээлийг буцааж төлөх тохиролцоо хийсэн. Цаашилбал Оюу Толгойд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 75% өр, 25% хувьцаа бөгөөд энэ нь Монголын хууль тогтоомжоор татвараас чөлөөлөгдөх зээлийн хүүний зөвшөөрөгдсөн дээд хязгаар юм. Энэ өрийг үйлчлэхийн тулд Оюу Толгой ХХК (эл уурхайн эзэн) Рио Тинто группд багтах гадаадад байдаг зээлдүүлэгчдэд нь хүү төлөх юм. Энэ нь Оюу Толгой ХХК-ийн олох ашгийн хэмжээг бууруулж, улмаар Монгол Улсын Засгийн газарт ногдох ашгийг бууруулна. Нийт хөрөнгө оруулалт нь дор хаяж 14.6 тэрбум долларт хүрсэн уурхайгаас зээлээ төлж гүйцсэний дараа Монгол ердөө 200 сая долларын ногдол ашг авах болохыг үүгээр л тайлбарлах юм.¹⁵³ Уурхайн монголын талын 34 хувиас тооцвол Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтын өгөөж ердөө 4% -тай тэнцэнэ.¹⁵⁴ Гэхдээ, зээлийн өр, алдагдлыг урагш шилжүүлэх болон давтагдах зардал хэтрэлт ба хойшлолтыг тооцвол Монголын санд хэдий хэмжээний ноогдол ашиг орж ирэх нь тодорхойгүй байна. Үйлдвэрлэл эхлэх хугацааг 2021 оны I улирлаас III улирал болгон хойшлуулсан¹⁵⁵ тухай 2018 оны 10-р сарын TRQ-ийн мэдэглээс жилийн дараа 2019 оны 7-р сард Рио Тинто далд уурхайн барилгын ажлын хүндрэлтэй байдал үүснийг мэдээлснээр нийт хойшлолт 16-аас 30 сар болж үйлдвэрлэл 2023 оны 6-р сард эхлэх болсон¹⁵⁶. Эдгээр хойшлолт нь аливаа татвар ба ноогдол ашиг төлөлт МУ-ын хувьд мөн хойшлогдоно гэсэн үг. Хойшлуулалтаас болж зардал нь \$1.2-оос \$1.9 тэрбум доллар болж өсөх тухай мэдэгдэл нь илүү ноцтой асуудал юм¹⁵⁷. Энэ өсөлт нь төслийн зардлаа нөхөх хугацааг уртасгана – төсөл эзэмшигчид оруулсан хөрөнгөө нөхөж уурхайн ашгаас татвар төлж эхлэх хугацаа – улмаар МУЗГ-ын

151 Zand, B. August 7, 2013, <https://www.spiegel.de/international/world/mining-the-gobi-desert-rio-tinto-and-mongolia-fight-over-profits-a-915021-2.html> (2017-12-08).

152 2007 2 cap https://wikileaks.org/plusd/cables/07ULAANBAATAR119_a.html; (2008-12-01) https://wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR521_a.html; (2008-02-06) https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR68_a.html, https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR227_a.html; (2008-03-19) https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAANBAATAR118_a.html; https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR201_a.html; 2009-03-03: https://search.wikileaks.org/plusd/cables/09ULAANBAATAR87_a.html (2019-04-26), see also Hook, L. October 15.

153 Rio Tinto website, e01 8, https://www.riotinto.com/documents/RT_Oyu_Tolgoi_Past_Present_and_Future_EN.pdf, p. 11 (2019-04-212).

154 As total investment will have been \$14.6 billion, Mongolia's investment will have been 34% of that, or \$4.9 billion. Dividing the \$200 million by \$4.9 billion gives the return on investment of roughly 4%.

155 TRQ, Хэвлэлийн мэдээ, 2019-02-26 (2019-12-18).

156 Rio Tinto, 2019-07-16 OT-н далд уурхайн талаарх мэдээлэл <https://www.riotinto.com/news/releases/Oyu-Tolgoi-underground-project-update> (2019-12-18).

157 Мөн тэнд.

ОТ-оос авах ноогдол ашгийг улам бууруулах юм. SalingStones Capital мэт бусад хувь нийлүүлэгчид мөн энэ асуудалд санаа зовниж байгаа.¹⁵⁸

Financial Times¹⁵⁹ сонинд саяхан гаргасан нийтлэлд нотолсноор Монгол Улсын Оюу Толгойд эзэмшиж буй 34 хувийн хувьцаа үнэд хүрэхгүй хэмээн тооцсон байна. Хөндлөнгөөс харахад, Оюу Толгойн хувь эзэмшлийг баталгаажуулахад чиглэсэн МУЗГ-ын ажиллагааг буруу чиглүүлсэн байх магадлалтай, жижиг хувьцаа эзэмшигчийн хувьд төсөлд, нэн ялангуяа төслийн өртөгт нөлөөлөх арга байхгүй, Оюу Толгойн санхүүжилтийн ээдрээтэй бүтэцтэй нь харьцуулж жигнэвэл Монголын эзэмшил хэмжээ нь хүлээсэн хүлээлтэд хүрэхгүй төлөвтэй.

Ашиг, үр өгөөжийг нь дэвэргэж, тулгамдах бэршээлийг бууруулан тооцох практик энэ төрлийн мега төслийн хөгжлийн хувьд түгээмэл бөгөөд олон жил үргэлжилж байгаа асуудал юм¹⁶⁰. Зардал хэтрэлт ба хугацаа алдалт байж болох боловч санхүүгийн загварчлалд тусгагдаагүй байдаг юм. Цаашилбал, ийм төрлийн төслийн санхүүгийн загварчлалд уул уурхайн олон экстерналиити хэмээх асуудлуудыг тусгадаггүй. Үүний нэг жишээ бол Оюу Толгойгоос учирч буй экологийн хохирлыг тооцоолоход хэцүү боловч Оюу Толгойн орчмын хүн ам ба ландшафтад урт хугацааны ихээхэн сөрөг нөлөөтэй байх юм. Энэ нь ялангуяа ил уурхай ба газрын гүнд блок кейв олборлолт хосолсон газар томоохон талбайд ландшафтын эвдрэл ба нуралт үүсэх аюул нүүрлэнэ. Үүний дээр уул уурхайтай холбоотой хөрс, усны бохирдлоос гадна Оюу Толгой руу татсан ус мөн голын гольдрол өөрчилснөөс Говь нутгийн эмзэг эко системүүд ганд автаж, биологийн олон янз байдал хохирол учруулж байна.¹⁶¹ Оюу Толгойн орчимд амьдардаг нүүдэлчин малчдын амьдрал, ахуй доройтуулсныг Оюу Толгой ХХК эсрэг гаргасан малчдын нэхэмжлэлийг 2017 онд¹⁶² хүлээн зөвшөөрч гомдлыг барагдуулах гэрээ байгуулж шийдэх гэж оролдож байгаа ч экологийн доройтол, нийгмийн ялгаварлын асуудлууд шийдэгдээгүй хэвээр байна¹⁶³.

4.2 Оюу Толгойн гацаа

2009 онд ОТХОГ-д гарын үсэг зурсны дараа болон Дубайн гэрээ гэх 2015 оны далд уурхайн барилгын санхүүжилтийн төлөвлөгөө (ОТДУББСТ)-нд гарын үсэг зурахаас өмнө, хронологийн хайрцагт бүрэн тайлбарласан, бартаатай хэдэн жил өнгөрөв. ОТХОГ-д гарын үсэг зурснаас хойшхи арван жилийн хугацаанд дахин хэлэлцээр явуулах бүх оролдлого

158 SailingStone Capital, (2019-04-23) [https://sailingstonecapital.com/pdf/SailingStone%20Capital%20Vote%20No%20TRQ%20Letter%20\(04-23-2019\).pdf](https://sailingstonecapital.com/pdf/SailingStone%20Capital%20Vote%20No%20TRQ%20Letter%20(04-23-2019).pdf).

159 Sanderson, H. & N. Hume, 2019-02-23, https://www.ft.com/content/7d8101c0-a7e3-11e9-b6ee-3cdf3174eb89?accessToken=zwAAAWxsCUa4kc99gQHAp-MR6dO27jzfMXTriQ.MEUCIQc8YjAgbr7s9hDPtEUpJN-CyzOEAY59byqtqaCzlglogKQI-ge520TxaRqMDWXZyjm_sNOyoQ9Q-GgmAwZbbHooNolG&sharetype=gif?token=24cc25bf-67ed-432e-b4d1-468a30513f4f (2019-0808).

160 Besant-Jones et al 1994: 42, мөн Flyvberg, B (Ed) 2017.

161 See Jackson 2018.

162 Accountability Counsel: <https://www.accountabilitycounsel.org/client-case/mongolia-south-gobi-mining/#impact>.

163 Rod Austin, 2019-08-08, <https://www.theguardian.com/global-development/2019/apr/08/mongolian-herders-corporate-behemoth> (2019-12-01).

бүтэлгүйтэв¹⁶⁴. 2019 онд хийсэн сүүлчийн оролдлогоор парламентаас Оюу Толгойн уурхайтай холбоотой бүх гэрээг Монголын ард түмний эрх ашигт нийцүүлэн хянах арга хэмжээ авахыг үүрэгдсэн тогтоол батлагдав.¹⁶⁵ Монгол Улс Оюу Толгойн ашгаас хэдий хэмжээний, хэзээ ашиг хүртэх ба хэдий хэмжээний татвар Монголд төлөх ёстой вэ гэдэг нь хамгийн маргаантай асуудлууд байв.

Гэтэл дэлхийн зах зээл болон ГШХО-ын дэглэмд орсон Монгол Улсад маневрлах орон зай бага. ОТХОГ, ялангуяа хөрөнгө оруулалтыг хамгаалах хоёр талын гэрээнүүд байгуулж тэдгээрт хөрөнгө оруулагч ба улсын хоорондын маргааныг таслах (ISDS) заалтыг оруулснаар Монгол Улс энэхүү олон улсын эрх зүйн орчинд баригдана. 2015 оны Дубайн гэрээгээр энэхүү орчныг улам бататгаснаар Монгол Улс өөрийн ард түмний эрх ашиг бус харин хөрөнгө оруулалтын баталгаатай орчинг зорьсон гарцгүй замд оруулсан.

4.2.1 Хөрөнгө оруулагч ба улсын хоорондын маргаан таслах (ISDS) заалт

Яригддаггүй нэгэн зүйл бол МУЗГ нь Рио Тинто болон түүний бусад хөрөнгө оруулагчдад шаардлага тавих боломж хязгаарлагдмал буюу шаардлагаа хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь боогдмол байдагтай холбоотой. Энэ нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Монгол-Нидерланд хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан Хөрөнгө оруулагч ба улсын хоорондын маргаан таслах (ISDS) тухай заалттай холбоотой юм. ISDS заалт нь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын маргаан үүссэн тохиолдолд хүлээн авагч засгийн газрыг шүүхэд өгөх боломжийг олгодог. Гомдлыг бие даасан шүүхэд гаргаж, холбогдох ISDS заалтад хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай зүйлчлэлийг зөрчсөн эсэхийг шүүгчид шийдвэрлэдэг байна. Эхлээд гадаадын хөрөнгө оруулалттай улс орнуудын төр засаг нь компаниудыг дур зоргоороо дарамтлахыг зогсоох зорилго бүхий ISDS заалт нь яваандаа улс орнуудын төрийн хэрэгт оролцох ба бүр ард түмнийхээ ашиг сонирхолд нийцүүлэн төрийн хууль тогтоох эрхэнд халдах боломжийг корпорацуудад олгох механизм болж хувирсан юм.¹⁶⁶ ISDS систем нь нэг талыг барьсан – зөвхөн корпорацид төрийг шүүхэд өгөхийг зөвшөөрдөг, эсрэгээр болдоггүй – барьцгүй ба өндөр өртөгтэй¹⁶⁷, мөн корпорацийн ашиг сонирхлыг олон нийтийн ашиг сонирхолтой хуулийн хүрээнд сөргөлдүүлэх боломжийг олгодог байна.¹⁶⁸

164 Оюундарь, Э. 2015.07.25 МР О. Содбилэг: Дубайд байгуулсан ОТ гэрээг арбитрын шүүх хэрэгсэхгүй <https://theubposts.com/has-the-oyu-tolgoi-s-dubai-deal-been-voided/> (2019-12-01).

165 Балжмаа/Г, November 21, 2019, <https://www.montsame.mn/en/read/207811>, <https://www.reuters.com/article/us-mongolia-oyutolgoi-idUSKCN1UE1P1> (2019-12-01).

166 Provost, C. 2016, <https://www.tni.org/files/publication-downloads/taxes-on-trial.pdf> (2019-12-01).

167 Hughes, L. 2017, <https://www.ciel.org/governments-look-narrowly-problems-undemocratic-investor-state-dispute-settlement/> (2019-09-28).

168 <https://www.documents.clientearth.org/wp-content/uploads/2017-03-15-towards-a-more-diligent-and-sustainable-system-of-investment-protection-ce-en.pdf> (2019-09-28).

Оюу Толгойн хувьд 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээ, Монгол-Нидерландын хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээ аль алинд ISDS заалт орсон байгаа. SOMO-гийн «Уул уурхайн татвар» тайланд нарийвчлан тайлбарласнаар Рио Тинто нь Люксембург ба Нидерландын татварын диваажин дэх шуудангийн хайрцгийн охин компаниудаараа дамжуулан Оюу Толгойд хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Иймд тус уурхайг хянадаг Монголын хуулийн этгээд болох Оюу Толгой ХХК-ийн хувьцааны 66 хувь нь Туркойз Хилл Ресурс группын нэг хэсэг болох Голландын «Оюу Толгой Нидерланд Б.В» компанид харьяалагддаг. Оюу Толгой Нидерланд Б.В. компани ганц ажлын орон тоотой бөгөөд зөвхөн Монгол руу орж буй санхүүгийн урсгалыг дамжуулах, түүнчлэн Рио Тинто болон бусад корпорацийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг хамгаалах арга хэрэгсэл юм. Эдийн засгийн бодит субъект биш хуулийн этгээдээр дамжуулан хоёр талын гэрээнд тусгагдсан хөнгөлөлтийг хууль бус аргаар эдлэх нь эдгээр гэрээний зорилгыг ташааруулж байгаа үзэгдэл мөн. Ийм ажиллагааг гэрээ арилжих гэж нэрлэдэг болно.

МУЗГ-аас Рио Тинто ба түүний хамтарсан хөрөнгө оруулагчид Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөлийг зөрчсөн гэж үзвэл НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-т¹⁶⁹ нэхэмжилж болно. Харин, Оюу Толгой компанийн эзэд Монгол, Нидерландын Хөрөнгө оруулалтын гэрээний «шударга, тэгш хандах» гэсэн өргөн томъёололтой нөхцлүүдийг Монгол Улс зөрчсөн гэж үзвэл Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвд хандана.¹⁷⁰ 2008 оны яриа хэлэлцээнд АНУ-ын засгийн газрын төлөөлөгчид АНУ-ын корпорацийн хөрөнгийг хураах асуудал гарвал ийм хэрэг үүснэ гэж монголын түншүүддээ анхааруулж байв:

«Хөрөнгө оруулалтад буй Засгийн газрын хувийг үнэ төлбөргүй «авах» оролдлого нь АНУ, Монгол Улсын хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээ (BIT) -ний заалтуудад суусан АНУ-ын экспроприацийн эсрэг хуулийг үйлчлүүлж болзошгүй гэж [АНУ-ын] Түр хамаарагч тэмдэглэ1.»¹⁷¹

Рио Тинто ба Засгийн газрын хоорондын зөрчилдөөний олон нийтийн мэдээлэлд хүрсэн тохиолдлуудын ихэнх нь татварын ямар нэг хэлбэртэй холбоотой байдаг. 2011 онд цуцлагдсан 2006 оны гэнэтийн ашгийн татвараас эхлээд 2012–2019¹⁷² оны хооронд Оюу Толгойгоос авах татварын орлогыг нэмэгдүүлэх гэсэн МУЗГ-ын төрөл бүрийн оролдлогууд, татвар болон ашгийг хуваах асуудлын нэг талд Рио Тинто ба түүний хөрөнгө оруулагчид, нөгөө талд нь Засгийн газрын зөрчилдөөний талбар байсаар ирсэн. Бусад ертөнцөд, ISDS заалтаар татвартай холбоотой 40 гаруй хэрэг үүсгэхэд хүргэсэн байдаг бөгөөд корпорациуд хууль тогтоомжийн өөрчлөлт ба татварын байгууллагуудын хуулийн тайлбар, хэрэгжүүлэлтэд гомдол гаргасан байдаг.¹⁷³ Энэхүү систем нь татварын эргэн тойронд иймэрхүү хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх боломжийг олгож байгаа нь – зөрчилдөөний шийдлийг олоогүй тохиолдолд – Монголын Засгийн газрыг олон улсын шүүхэд татах

169 2009 ОТХОГ, 14.2 зүйл анги http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_EN.pdf (2019-09-28).

170 Монгол-Нидерландын ХОГ, <https://investmentpolicy.unctad.org/international-investment-agreements/treaties/otheria/2563/mongolia---netherlands-bit-1995-> (2019-09-28).

171 https://search.wikileaks.org/plusd/cables/08ULAAANBAATAR227_a.html (2019-09-28).

172 https://www.somo.nl/wp-content/uploads/2018/01/Mining_taxes_V_1.2.pdf p.22-23 (2019-09-28).

173 <https://www.tni.org/files/publication-downloads/taxes-on-trial.pdf> (2019-09-28).

магадлал өндөр байна. Монгол Улсын Засгийн газар 2018 оны 3-р сард Туркойз Хилл Ресурс компанид 155 сая долларын татварын нэхэмжлэл гаргасны дараа тус компани Монгол Улсын Засгийн газарт маргаантай байгаа тухай мэдэгдэл бүртгүүлсэн нь ISDS-ийн хэргийг эхлүүлэх эхний алхамаа хийсэн хэрэг юм.¹⁷⁴

Монгол, Нидерландын Хөрөнгө оруулалтын гэрээ, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан ISDS заалтууд нь Монгол Улсын Рио Тинтотой хэлэлцээр хийх орон зайг алдагдуулах, тэр байтугай нийтийн ашиг сонирхлыг хангах шаардлага тавих боломжийг хязгаарлаж магадгүй юм. Оюу Толгойд хамаарах тохиролцоонуудыг бэхжүүлснээр эдгээр ISDS заалтууд нь Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой асуудлуудыг улам бүр хүндрүүлж байна.

4.2.2 2015 оны ОТДУББСТ / Дубайн гэрээ

ОТДУББСТ нь ОТ уурхайн хоёр дахь (далд уурхайн) үе шатыг дэмжих санхүүжилтийн гэрээ юм. Хоёрдугаар үе шатны далд уурхайн гэрээ нь анхны хөрөнгө оруулалтын гэрээг бэхжүүлсэн. Энэхүү хэлэлцээр нь 2015 онд Дубайд байгуулагдсан бөгөөд дараахь гурван шалтгаанаар онцлог юм: Нэгдүгээрт, уул уурхайн салбарт төрийн санхүүжилтийн оролцоотой хамгийн том хэлэлцээр буюу нийт 4.4 тэрбум ам.долларын санхүүжилттэй¹⁷⁵ Хоёрдугаарт, МУЗГ-аас 2009 оны Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцлийг өөрчлөх аливаа боломж, хувилбаруудыг арилгасан гэрээ. Гуравдугаарт, Дубайн гэрээг гарын үсэг зурахаас өмнө парламентаар оруулж хэлэлцүүлээгүй болон Захиргааны шүүхээс процессийн алдаатай хэмээн шийдвэр гарсан тул хүчин төгөлдөр эсэх нь эргэлзээтэй.¹⁷⁶

Энэхүү төрийн аврага том санхүүжилтийн гэрээ нь Европын сэргээн босголт хөгжлийн банк¹⁷⁷ (ЕСБХБ)-наас олгосон зээл 400 сая ам.долларын зээл, А зээл гэж нэрлэгддэг арилжааны банкуудын синдикат болж хамтарсан 1 тэрбум хүртэлх зээлийг В зээл гэж нэрлэнэ. Түүн дээр 500 сая ам.доллар нь АНУ-ын Экспортын импортын банкнаас¹⁷⁸, мөн Олон улсын санхүүгийн корпорациас (ОУСК)¹⁷⁹ олгосон 1,2 тэрбум ам долларын

174 Sanderson, Cosmo, 2018-03-16, <https://globalarbitrationreview.com/article/1166728/mongolia-risks-licia-claim-over-mining-tax-bill> (28 September, 2019).

175 http://www.ifc.org/wps/wcm/connect/industry_ext_content/ifc_external_corporate_site/ogm+home/priorities/mining/oyutolgoi2c (2019-09-28).

176 <https://theubposts.com/has-the-oyu-tolgoi-s-dubai-deal-been-voided/>, <https://www.riotinto.com/news/releases/Administrative-court-proceedings-Mongolia> (2019-11-23).

177 <http://www.ebrd.com/work-with-us/projects/psd/oyu-tolgoi-.html> (2016-12-12).

178 \$494,565,125; Export-Import Bank of USA, "Ex-Im approves \$500 million to Finance US Exports for Use in Mongolian Mine", 2013-05-16 <https://www.exim.gov/news/ex-im-approves-500-million-finance-us-exports-for-use-mongolian-mine>.

179 International Finance Corporation, Project number 29007, 2013-02-28.

зээл нь 821 сая долларын синдикат¹⁸⁰ өрийг багтаана. Олон улсын хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (MIGA) нь нийт 13 зээлдүүлэгчид 1 тэрбум доллараар баталгаа гаргаж өгөв.¹⁸¹ Зургаан тэрбум ам.долларын өрийн дээд хэмжээг зөвшөлцөж, шаардлагатай бол 1.6 тэрбум ам долларын нэмэгдэл зээлийг авах сонголттой. Эдгээр зээлийг 2013 онд¹⁸² тохирсон боловч Рио Тинто 2009 оны ОТХОГ-г шинэчлэх бүх оролдлогыг арилгаж чадсан гэж үзэж 2015 онд гарын үсэг зурав.

Энэхүү төслийн санхүүжилт оролцож буй төрийн ба төрийн баталгаатай санхүүжилтын зөвхөн мөнгөн дүн нь гайхалтай биш. 2015 оны ОТДУББСТ нь өмнөх ОТХОГ болон НӨХНГ-ний аль алины нөхцлийг нэгтгэсэн байдалд оршино. Үүнд зэс хайлуулах үйлдвэр (3.5 зүйл анги)-ээс гадна маргаантай Тавантолгойн нүүрсээр галлах цахилгаан станцын асуудлыг тодорхой тусгасан (3.4 зүйл анги) юм. Ил уурхайн барилгын нийт өртөг (эхний үе шат)-ын зардлыг аль ч тал маргах гарцгүйгээр тохирсон (4.3 зүйл анги). Дубайн гэрээнд гарын үсэг зурснаар 2010 оноос 2014 он хүртэлх бүх санхүүгийн тайланг баталж (4.4 зүйл анги), татварын хөнгөлөлт 0.6 тэрбум, алдагдлын үлдэгдэл 0.25 тэрбум (4.5 зүйл анги).

Дубайн гэрээг Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт хийхэд найдвартай улс гэх нэр хүндийг хамгаалах алхам болсон хэмээн сайшаадаг. Рио Тинтогийн хэвлэлийн мэдээнд Ерөнхий сайд асан Ч. Сайханбилэгийн мэдэгдсэнээр:

«Монгол улс эргээд бизнест орлоо. Оюу Толгойн дэлхийн хэмжээний зэс-алтны уурхай ба түүний цаашдын хөгжил МУ-ын эдийн засагт чухал ач холбогдолтой. Бид Монгол Улсын урт хугацааны өсөлтэд тууштай шинэ харилцан ойлголцлын бүтээлч харилцааны суурийг сэргээн тогтоож түншүүдтэйгээ урагшлах замаа эцэслэсэн болно.»¹⁸³

Угтаа бол ОТДУББСТ-д гарын үсэг зурснаар Засгийн газар нь Монголчуудад илүү сайн гэрээ хэлэлцэх бүх хаалгыг хаасан юм.

180 Зээлдүүлэгчид нь Канадын Экспортын хөгжил, Австралийн Экспортын санхүүжилт ба даатгалын корпорац, Standard Chartered, BNP Paribas, Канадын Imperial Bank of Commerce, KfW-IPEX, Netherlands Development Finance Company (FMO), Австрали ба Шинэ Зеландын банкны групп, Австралийн Үндэсний банк, ING bank, Intesa Sanpaolo, Natixis, Societe Generale CIB, Credit Agricole, Honakona and Shanahai Bankina Corporation (HSBC), The Bank of Tokyo- Mitsubishi UJF and Sumitomo Mitsui Bankina Corporation (SMBC). (<https://www.gtreview.com/news/asia/oyu-tolgoi-financing-agreed/>), (July 8, 2017)

181 MIGA, 2016, <https://www.miga.org/project/oyu-tolgoi-llc> (2020-01-20).

182 Зүүлт 180 and 181-оос үзэх.

183 <https://www.riotinto.com/en/news/releases/Oyu-Tolgoi-shareholders-agreement-signed> (2017-12-07).

5 Дүгнэлт

«Одоогийн байдлаар Оюу Толгойн гэрээ нь Монгол Улсын иргэдэд ашиг тусаа өгөхгүй байна... Гадаадын хөрөнгө оруулалт татах нь сайн хэрэг. Гэхдээ энэ нь гадаадын хөрөнгө оруулалт зөвхөн гадны талд ашиг тустай байх ёстой гэсэн үг биш юм.»

Баттөмөр Баагаа, 2019 оны 7-р сар, Монгол Улсын Их Хурлын ажлын хэсгийн гишүүн.¹⁸⁴

Монголын иргэний нийгэм, улс төрчид 2003 онд Хөрөнгө оруулалтын гэрээний яриа хэлэлцээ эхэлснээс хойш Оюу Толгойн зэс алтны уурхайгаас олох ашгийн хүртээмжийн талаар асуулга тавьж, өөрийн баялгийг хэрхэх бүрэн эрхийг шаардсаар ирсэн. Монголчуудад Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний зорилго төдийгүй өөрсдийн хүртэх боломжтой өчүүхэн үр өгөөжид эргэлзэх хангалттай шалтгаан байгааг энэхүү судалгаа нотолж байна. МУ нь корпорацид таатай хөнгөлөлт амлаж «барууны» корпорацийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн төрийн санг дүүргэхгүй гэрээ байгуулсан юм. Гэрээг хэлэлцэх явц нь хүчний тэгш бус байдалд, олон улсын хүлээлтийг биелүүлэх шахалт дарамтанд, зөвхөн уул уурхайруу чиглэсэн зах зээлийн эдийн засагт шилжихэд хөтөлсөн институцийн шинэчлэлийн нөхцөлд явагдсаныг харуулахыг бид зорьсон юм.

Энэ тайлангаар бид эрдэс баялаг ихтэй орнуудыг олон улсын зохицуулалт бүхий маневрлах орон зайгүй дэлхийн зах зээлд нэгтгэдэг аргыг харуулав. Тайланд 'өрнөдийн' засгийн газрууд ба Бреттон Вудсын байгууллагуудын Монгол орны хөгжилд гүйцэтгэсэн бараан дүр зургийг харуулсан болно. Дэлхийн банк, ОУВС нь Монголын зах зээлийг либералчлахад голлох үүрэг гүйцэтгэж, эдийн засгийн хөгжлийг зөвхөн уул уурхайд тулгуурлахад чиглүүлж, гадаадын капиталд эрдэс баялгийг нь олборлох нөхцөл, таатай орчныг засч бүрдүүлжээ. Аль 2003 онд Дэлхийн банкнаас Олборлох үйлдвэрлэлийн тойм (EIR) судалгаанд байгалийн баялгийн олборлолт тогтвортой хөгжилд шууд хөрөвдөггүй гэх нарийвчилсан дүгнэлт хийгдсэнийг үл тоомсорлон, нэн ялангуяа засгийн газар, корпорацуудын хооронд байгуулах гэрээнүүд нь ирээдүйд байгаль орчин, нийгмийн зохицуулалт хийх боломжийг хязгааралдгийг мэдсээр байж үүнийг хийжээ.

Дэлхийн банк Монгол Улсыг уул уурхайн салбарлуу түлхэж эхэлсэнтэй зэрэгцээд АНУ нь – Дэлхийн банкны хамгийн том хувьцаа эзэмшигчийн хувьд – Оюу Толгойн ашигт малтмалын нөөцөд санаархсан барууны уул уурхайн компаниудад тавих шаардлагуудаа зөөллөхийг МУЗГ-аас зугуйхан шаардаж эхлэв. Орос, Хятадын нөлөөллийг буруулах Монгол Улсын «гуравдагч хөрш»-тэй байх улс төрийн хүсэл, мөн ОУВС-гаас ирэх санхүүгийн хамаарал аль алин дээр дөрөөлөн АНУ болон түүний холбоотнууд өөрийн арилжааны ашиг сонирхлоо амжилттай түрж чаджээ. Шинэчлэн тооцоолсон санхүүгийн загвар болон албаны хүмүүсийн гэрчлэлээс дүгнэхэд Оюу Толгойг зохицуулах гэрээ хэлэлцээрүүд нь санхүүгийн хувьд Монголын Засгийн газрын сэтгэлд төдийлэн нийцэхгүй байгаа юм. Ийнхүү өөрийн улсын эдийн засгийг хөгжүүлнэ гэх зорилгоор гадаадын

184 Dairtan, A. November, 21, 2019, <https://www.reuters.com/article/us-mining-riotinto-mongolia/rio-tinto-faces-having-to-renegotiate-terms-of-mongolian-copper-project-idUSKBN1XV278> (December 13, 2019).

компаниудыг уул уурхайн салбартаа оруулахад хөтөлж, дараа нь мөн компаниудтай тохиролцоо хийхэд нь өөрийн эрх ашгийг хөсөрдүүлэх дарамт шахалтад оруулжээ.

Энэ тайланд дурдагдсан АНУ-ын ЭСЯ-ны дипломат цахилгаан мэдээнүүд нь Монголын улс төрчид ард түмэндээ тааламжтай тохиролцоонд хүрч чадаагүйгээс гадна Оюу Толгойн талаарх олон нийтийн ойлголтыг буруу чиглүүлснийг харуулж байна. Яалаа ч АНУ-ын Рио Тинтог тууштай дэмжсэн байдал, уул уурхайн компаний ард жагссан бусад хандивлагч орнууд, Монгол Улсын ОУВС-аас хараат байдал ба АНУ-ын уг байгууллага дахь ноёрхол, уул уурхайгаас хамааралтай болсон эдийн засаг зэрэг бүх зүйл нь Оюу Толгойн гэрээг хэлэлцэхэд Монгол Улс хүчний тэнцвэргүй байдлыг давж чадах магадлал бага байсан талтай.

Оюу Толгой нь Монгол улсын бодлого боловсруулах чадварыг гурван аргаар булааж авсан бололтой. Эхнийх нь ОТХОГ ба түүн дэх олон улсын хөрөнгө оруулалт ба татварын хэлэлцээрүүдээр баталгаажсан тогтвортой байдлын болон арбитрын тухай заалтууд. Монгол Улс хууль тогтоомждоо ямар ч нэмэлт, өөрчлөлт хийхээс үл хамааран 2009 оны ХОГ-ны заалтууд нь Рио Тинто компанийн ашигт нөлөөлөхөөс хамгаалах төдийгүй засгийн газрын оролдлогыг эсэргүүцэх боломжийг олгосон байдал. Хөрөнгө оруулалтыг хамгаалах заалтууд нь Монголын засгийн газраас татварын хууль тогтоомжийг дахин боловсронгуй болгоход нь хаалт болж байна. Гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсаас амласан хөнгөлөлтүүд нь хөрөнгө оруулалтын хүчээр тогтвортой хөгжлийг хангахад шаардагдах бодлого хэрэгжүүлэх орон зайг хаасан байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд корпорацийн ашиг сонирхлыг дээгүүр тавих олон улсын болон хоёр талын хөрөнгө оруулалтыг хамгаалах гэрээнд гарын үсэг зурснаар Засгийн газар Монгол Улсын эрх ашгийг хамгаалах орон зайгүй болжээ. «Сайн засаглал» ба «хууль дээдлэх» гэгчийг дэмжих бодлого нь бодит байдал дээр засаглал хоорондын харилцан хянах тэнцвэрийг задалжээ.

Хоёр дахь нь 2015 оны Дубайн гэрээ юм. ОТХОГ-ний нөхцлийг бататгахын зэрэгцээ ОУСК, ЕСБХБ зэрэг төрийн санхүүжилттэй ОУСБ-уудыг багтаасан санхүүжилтийн нөсөр бүтцийг зүйлчлэн албажуулснаар тохиролцоог өөрчлөх орон зайгүй болгожээ. Гуравдахь нь гэрээний цаана өрнөдийн олон улсын хамтын нийгэмлэг, улс төр ба санхүүгээр томоохон жин дааж байгааг АНУ-ын ЭСЯ-ны цахилгаан мэдээ бэлхнээ харуулсан эдгээр байна.

Монгол Улсад ард түмэндээ үйлчлэх гэрээ хэлцэл тохирох шударга боломж анхнаасаа байгаагүй гэж хэлж болно. Дэлхийн эрх зүй ба институцийн тогтолцоо бүхий эдийн засгийн болон зохицуулалтын орчин нь капиталын чөлөөт урсгал ба эдийн засгийн өсөлтийг эрхэмлэсэн хөгжлийн парадигмтай. Энэ нь хөрөнгө оруулалтын аюулгүй орчныг хүн ба газар дэлхийн эрүүл аюулгүй орчноос дээгүүр тавихад хүргэдэг. Бусад нөлөөлөлд, тухайлбал, 2007-2008 оны санхүүгийн хямралтай зэрэгцэн үүссэн улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн элитүүдийн хольбиромтгой байдал зэрэг хүчин зүйлүүд нь Монголын хэлэлцэх чадавхийг улам бүр дордуулсан болно. Иймээс Рио Тинто зэрэг дэлхийн уул уурхайн аварга компаниуд нь «барууны» төрийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын бодлогын орон зай, баялгийн олборлолтыг хянах, зохицуулах, хяналтандаа байлгах байдалд

нөлөөлж улмаар улс гүрний хөгжлийн чиг хандлагад сөргөөр нөлөөлсөн байна. 2017 онд гадаадын компаниудын санхүүгийн урсгалыг Монголын банкуудаар дамжуулах монголын санаачлагыг эсэргүйцсэн «Рио Тинто» -гийн заргыг ОУВС-гаас дэмжсэн нь Монгол дахь ардчилсан шийдвэр гаргалтыг корпорацийн хүчээр дарж байгааг сэтгэл өвдөм тод харуулсан. Оюу Толгойн гэрээг хэлэлцэх явц нь гадаадын болон корпорацийн ашиг сонирхлоор дипломат, институци, улс төрийн хүчийг ашиглан баялаг ба экологи, нийгмийн сайн сайхныг ардчилсан байдлаар хэрэгжүүлэхийг сөрсөн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж буйг харууллаа.

Дэлхийн банкны группийн практикийг шүүмжилсэн Олборлох үйлдвэрлэлийн тойм тайлан (EIR) 2003 онд нийтлэгдсэнээс хойш 6 жилийн дараа ОТХОГ-нд гарын үсэг зурсан. EIR-ын гол зөвлөмж нь тогтвортой хөгжлийг эдийн засгийн төрөлжүүлэлтээр дэмжих тухай байсан. Харамсалтай нь, EIR-ын энэ зөвлөмж Оюу Толгойн хувьд ч үнэн бөгөөд бусад зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн бол Монголын ард түмэнд ч, Оюу Толгой төсөлд ч ашиг тусаа өгөх байжээ.

Төслийн цар хүрээ ба хэмжээ нь Монгол Улсыг олон улсын улс төрийн эдийн засаг ба түүний корпорацийн ашиг сонирхлыг эрхэмлэх Гадаадын шууд хөрөнгө оруулалтын зохицуулалтын дэглэмд чулууджээ. Иймд, аливаа өөрчлөлт оруулах нь олон улсын түвшиний үйл ажиллагааг шаардана. Энэ нь ОУСБ-ууд, тухайлбал, Дэлхий банк, ОУВС, ОУСК ба ЕСБХБ-ны зүгээс засаглалын хяналтын тэнцвэрийг алдагдуулах нөхцлийг улс орнуудад тулгадаг явдлыг зогсоох хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч, арга хэмжээ авахыг шаардана.

Монголчуудад өөрийн баялгийг ашиглах, түүнд эзэн суухын тулд үндэстэн дамнасан талуудын дэлхийд хууль ёсны хэмээн ойлгуулсан энэ баялгийн дээрмийг зогсох шаардлагатай. Энэ нь бид «сайн засаглал» ба «хуулийг дээдлэх» гэх ойлголтуудыг корпорацийн сонирхол ба ашиг олзлох горимоос холдуулж эрүүл газар дэлхий ба түүний нийт хүн амд чиглүүлэн шинэчлэн тодорхойлох хэрэгтэйг цохож байна.

6 Зөвлөмж

Рио Тинтод

- Рио Тинто нь Монголчууд өөрийн газар нутаг дээрх хамгийн том эрдэс баялгийн ордоосоо хязгаарлагдмал өгөөж хүртэх гэж байгаа Монгол Улсын зовнилыг харгалзсан эргэж харах шаардлагатай. Оюу Толгойн баялаг ашигласны төлбөрийн талаар маргаан үргэлжилсээр байгааг харгалзан илүү шударга гэрээнд хүрэх зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хэлцлийн ширээнд эргэн суух нь Рио Тинто ээлтэй болно. Оюу Толгойн гэрээний тогтворжуулалтын заалтаас сайн дураар татгалзах нь Рио Тинто ба Монгол Улсын Засгийн газрын хооронд бүтээлч болон тогтвортой харилцаа тогтооход эхний сайн алхам болох юм.
- 2015 оны Дубайн гэрээнээс хойш зурагдсан гэрээнүүдийн зээлийн нөхцлийн болон бусад гол баримт бичгүүдийг бүрэн нээлттэй болгох.
- Рио Тинто уурхайн ирээдүйн ашигт байдал болон МУ-д ноогдох орлогын талаарх эргэлзээтэй байдлыг тодорхой болгох зорилгоор Оюу Толгойгоос олборлосон эрдэс баялгийн шилжүүлэлтийн үнэ, уурхайн ашгийн талаарх мэдээллийг ил тод болгох.
- Рио Тинто бүх EPC (engineering, procurement, construction) гэрээг ОТ ХХК-аар хийлгэх замаар үйл ажиллагааны зардал ба менежментийн зардлын ил тод байдал, тайлагналыг дэмжих.
- МУ-ын УИХ-ын 2019 оны 11 -р сарын «Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай» 92-р Тогтоолыг хүлээн зөвшөөрч, нийцүүлэн хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засгийн Газарт

- Монгол Улс нь ирээдүйн хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд гадаадын хөрөнгө оруулагчид чиглэсэн хэт их сөрөг үр дагавартай татвар хөнгөлөх заалт бүхий санхүүгийн тогтворжуулалтын болон татвараас чөлөөлөх нөхцлийг тохирохгүй байх.
- Оюу Толгойн хувьд, Монгол Улс нь Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ОУХАХБ)-ын зөвлөмжийн дагуу ОТХОГ-нд буй санхүүгийн тогтворжуулалтын заалтыг эргэн хэлэлцэх хэрэгтэй.
- Монгол Улс компанид арбитрын шүүхэд хандах эрхийг нээсэн заалт бүхий Хоёр талын хөрөнгө оруулалтыг хамгаалах гэрээ (ХХОХГ)-нүүдээ эргэж харж дахин хэлэлцэх хэрэгтэй. Компаниуд зохиомол корпорацын бүтцийг бий болгож, ийм гэрээнд заасан хөнгөлөлтүүдийг эдлэх нь Монгол Улсын нийтийн ашиг сонирхлын хууль тогтоомж,

засаглалд эрсдэлтэй. Иймд Монгол Улс арбитрын заалтыг одоо байгаа бүх хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээнээс хасахыг эрэлхийлэх болон ирээдүйн гэрээнд тохирохоос татгалзах хэрэгтэй. Цаашид BIT хэлэлцээр байгуулахдаа Монгол Улс дор хаяж:

- Гэрээний зөрчлийг олон улсын гэрээний зөрчлийн түвшинд хүргэдэг «шүхэр заалтыг» хүлээн авахгүй байх;
 - Татварын зайлсхийлтээс хамгаалсан хүчтэй зүйлчлэл оруулах;
 - ISDS-ийг хасах эсвэл нэмэлт санал гаргах, тухайлбал үндэсний механизмуудыг барагдуулсны дараа.
- Монголын Засгийн газар хүчтэй КНХ (компанийн нийгмийн хариуцлага), олон нийтийн ашиг сонирхол ба тогтвортой хөгжлийн зарчим\томъёо болон дээр дурдсан зарим элементүүдийг агуулсан өөрийн BIT загварыг боловсруулж болох юм.
 - Монгол Улс Нидерландтай байгуулсан ХХОХГ-ээг дахин хэлэлцэх ажлыг нэн тэргүүнд хийх хэрэгтэй. ХХОХГ-ний хугацаа нь 2021 оны 6-р сарын 1-ээс эхлэн 10 жилийн хугацаанд автоматаар сунгагдах заалттай. Иймд 2020 оны 12-р сарын 1-ний өдрөөс өмнө цуцлах саналаа хүргүүлэх шаардлагатай. Монгол Улс Нидерландын засгийн газрыг уг хуульд заасан арбитрын заалтыг хасахын тулд ХХОХГ-ээг дахин хэлэлцэх хийхийг шахах хэрэгтэй. Хэрэв амжилтгүй болбол МУ нийтийн ашиг сонирхлоо хамгаалах хууль тогтоох эрх мэдлээ бататгахын тулд гэрээг бүхэлд нь цуцлах талаар бодолцох хэрэгтэй.
 - Монгол Улс хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрийг зөвшилцөх нөхцлүүдээ эргэж харах хэрэгтэй. Энэ үйл явцад Монгол Улс нийгмийн сайн сайхан, экологийн бүрэн бүтэн байдлыг эрхэмлэх техникийн туслалцаа авах, ингэхдээ богино хугацааны улс төрийн ашиг сонирхол бус урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилго бүхий иргэний нийгэм, байгаль орчны засаглал, нөөцийн менежмент засаглалын мэргэжилтнүүд зэрэг талуудыг оролцуулах шаардлагатай.
 - Монгол Улс баялаг олборлох томоохон төслүүдэд хамаарах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи мэдээллийг илүү нээлттэй, цогц байдлаар Монголын ард түмэнд хүргэх ёстой. Бүх эерэг ба сөрөг талуудыг нийтэд мэдээлэх шаардлагатай бөгөөд ингэснээр болзошгүй эрсдэл, өртөгийг хэн хариуцах нь олон нийтээр хэлэлцүүлэгдсэн байх шаардлагатай. Монгол Улс ийм төслөөс авах боломжтой орлого ба хугацааны бодит тооцоог эцсийн шийдвэр гаргахаас өмнө гаргаж өгөх шаардлагатай. Орон нутгийн оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх явц бодитой байх ёстой бөгөөд тайланг олон нийтэд нээлттэй байлгах зорилгоор ИНБ-ын төлөөллийг оролцуулах шаардлагатай.
 - Олборлох төслийн үр өгөөжийг таамаглахад ашигласан санхүүгийн загваруудад хөрөнгө оруулалтын гэрээний санхүүгийн нөлөөлөл болон ус, хөрс, биологийн олон янз байдалд байгаль орчинд үзүүлэх урт хугацааны нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг багтаасан байх шаардлагатай.

- ▣ Монгол Улс ОУСБ-тай байгуулах санхүүжилтийн бүх зохицуулалтыг парламентаар батлах шаардлагатай.
- ▣ Монгол Улс Оюу Толгой болон бусад стратегийн ордуудын хувьд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс улс төрч, дипломат болон ОУСБ-ын ажилтнуудын ёс зүйн дүрмийг нэвтрүүлэх хэрэгтэй. Ийм ёс зүйн код нь ашиг сонирхлын зөрчилтэй аливаа ажилд авахгүй байх гурван жилийн «хөргөх хугацааг» багтаасан байх шаардлагатай.

АНУ-ын засгийн газар ба түүний дипломат түншүүдэд

- ▣ 2003 оны Олборлох үйлдвэрлэлийн тойм тайланг судлан үзэж компаниудын хувийн ашигт төвлөрсөн байдал болон баялгийг олборлох үйлдвэрлэлийг хөшүүрэгдэх нь ямар хүчтэй сүйтгэх үйлдэл болохыг ойлгох. Монголын иргэний нийгмийн монгол хүний эрх, соёлын өв, өвөрмөц үзэсгэлэнт байгаль экологийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх тухай удаа дараа гаргасан уриалгыг сонсож, үйлдэх хэрэгтэй.
- ▣ Дипломат хүчин чармайлт нь олныг хохироон цөөнхийн эдийн засгийн ашгийг эрхэмлэхээс татгалзаж үндэсний болон олон улсын эдийн засгийн ашиг сонирхлыг тогтвортой хөгжлийг хангах зорилгод нийцүүлэх шаардлагатай.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг Олон улсын санхүүгийн байгууллагуудад

- ▣ Өнгөрсөн алдаанаасаа суралцаж, Дэлхийн Банкны 2003 оны Олборлох үйлдвэрлэлийн тойм тайлан, Бреттон Вудсын төслөөс цуглуулсан зөвлөмж болон ОУСБ-ийн бие даасан үнэлгээний байгууллагуудаас өгсөн үнэтэй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.
- ▣ Бодлого боловсруулах тусгаар эрхийг сааруулж, хөгжлийн альтернатив замд саад болж, засаглалын хяналтын тэнцвэрийг хязгаарлаж буй эдийн засгийн бодлогын нөхцлүүдээ арилгах.
- ▣ Эдийн засгийн төрөлжилт, хөгжлийн тогтвортой байдлыг дэмжихэд бодлогын зөвлөлгөөгөө шилжүүлэх.
- ▣ Нөлөөлөлд өртсөн, өртөж болзошгүй иргэдтэй зөвлөлдөхийг зайлшгүй болон бодитой болгох бөгөөд ИНБ-ын төлөөллийг оролцуулж, тайланг олон нийтэд нээлттэй хүргэх шаардлагатай.
- ▣ Бүх зээлийн хэрэгсэлд орон нутгийн иргэдтэй орлого хуваарилах заалтыг суулгаж өгөх.

- Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг үндэсний болон орон нутгийн иргэний нийгэм, мэргэжилтнүүд баталсны дараа санхүүжилтийг хийх. Хүний эрх, хүрээлэн буй орчныг хамгаалах ажилд хяналт тавих, шаардагдах нөөцийг олгох.
- ОУВС, Дэлхийн банкны группэд, хүлээн авагч улс орнуудын соёл, улс төр, эдийн засгийн тэргүүлэх зорилгыг ойлгох чадавхыг нэгтгэж бий болгох. Монгол улсын хувьд энэ нь түүний соёлын өвийг илүү сайн ойлгох, тэр нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэргүүлэх чиглэлд хэрхэн шингэхийг харгалзах.
- 2015 оны Парисын уур амьсгалын өөрчлөлтийг тохиролцоогоор авсан амлалтуудыг хүндэтгэх, өнгөрсөн хугацааны хөрөнгө оруулалтад өртөж хохирсон нутгийн хүн ам. Жишээлбэл: Оюу Толгойн төслийн хөрөнгө оруулалтад өртсөн нутгийн бүлгүүдэд алдагдсан нөөцийг нөхөх дэмжлэг үзүүлэх.

Ишлэл

- Acosta, Alberto (2013) Beyond development: alternative visions from Latin America. EDS. Lang, M. and Mokrani, D. TNI and Rosa Luxemburg Foundation.
- Agosin, Manuel R. and Ricardo Mayer (2000) Foreign investment in developing countries Does it Crowd in Domestic Investment? UNCTAD Discussion paper No 146.
- Alfaro, Laura. et al, 2009, FDI, Productivity and Financial Development, *The World Economy*. doi: 10.1111/j.1467-9701.2008.01159.x
- Baatarzorig Tsolmon, Ragchaasuren Galindev, and Helene Maisonnave (2018). Effects of ups and downs of the Mongolian mining sector. *Environment and Development Economics* (2018), 23, 527-542. doi:10.1017/S1355770X18000153.
- Bebbington, A., L. Hinojosa, D. Bebbington, M.L. Burneo, X. Warnaars, (2008) Contention and ambiguity: Mining and the possibilities of development1 et al 2008, *Development and Change* (39) 6: 887-914.
- Besada, H & P. Martin (2013) Mining Codes in Africa: Emergence of a "Fourth" Generation? The North South Institute.
- Blunt, P. (2014) Whose resources are they anyway? Development Assistance and the community development agreements in the Mongolian mining sector. *Progress in development Studies* 14 (4): 383-399.
- Blunt, P. and G. Sainkhuu (2015) Serendipity and stealth, resistance and retribution: Policy development in the Mongolian mining sector. *Progress in development Studies* 15 (4): 371-385.
- Borensztein, E., L. De Gregorio and J.W. Lee, 1998, How does foreign direct investment affect economic growth? *Journal of International Economics* 45:115-135.
- Bulag, U. E. 2009. Mongolia in 2008: From Mongolia to Minegolia. *Asian Survey* 49 (1): 129-34.
- Bulag, U. E. 2009. Mongolia in 2008: From Mongolia to Minegolia. *Asian Survey* 49 (1): 129-34.
- Byambajav, D. (2012). Mobilizing Against Dispossession: Gold Mining and a Local Resistance Movement in Mongolia. Hokkaido University. <https://eprints.lib.hokudai.ac.jp/dspace/bitstream/2115/49267/3/02journal05-bvambaiaiv.pdf>. retrieved 5 December 2016.
- Carcovic Maria and Ross Levine, 2002; Does Foreign Direct Investment Accelerate Economic Growth? World Bank, available at <http://siteresources.worldbank.org/INTFR/Resources/fdi.pdf>, accessed 7 december 2018.
- Demirbag Mehmet, Ekrem Tatoglu & Adiya Oyungerel (2005) Patterns of Foreign Direct Investment in Mongolia, 1990-2003: A Research Note, *Eurasian Geography and Economics*, 46:4, 306318, DOI: 10.2747/1538-7216.46.4.306.
- Ganbold, M. and H.A. Saleem (2017) The peril and promise of resource nationalism: A case analysis of Mongolia's mining development. *Resources Policy* 53:1-11.
- Hatcher, Pascale (2012) Taming Risks in Asia: The World Bank and New Mining Regimes. *Journal of Contemporary Asia* (42) 3: 427-446.
- Hatcher, Pascale (2014) Regimes of risk: The World Bank and the Transformation of Mining in Asia. New York: Palgrave Macmillan.
- Hatcher, Pascale. (2016a) 'Le boom minier de la Mongolie et la montée du nationalisme des ressources: tensions politiques, promesses électorales et normes néolibérales' *Canadian Journal of Development Studies* 37 (4).
- Hatcher, Pascale. (2016b) The politics of artisanal and small-scale mining in Mongolia:, *Third World Thematics: a TWQ journal*, (1) 2: 184-201
- Husband, Charles; Songwe, Vera. 2004. Mongolia mining sector : managing the future (English). Washington, DC: World Bank. <http://documents.worldbank.org/curated/en/867261468323101510/Mongolia-mining-sector-managing-the-future>, accessed 7 december 2018.
- Jackson, S.L. 2018. Abstracting water to extract minerals in Mongolia's South Gobi Province. *Water Alternatives* 11 (2): 336356
- Jargalsaikhan, Sanchir (2016). Investment Treaties Between Mongolia and EU states: Implications for Mongolia's Development Prospects. Sustainable Strategy Institute, https://www.oefse.at/fileadmin/content/Downloads/tradeconference/Jargalsaikhan_Investment_Treaties_Between_Mongolia_and_EU_states_-_Implications_for_Mongolias_Development_Prospects.pdf, Accessed August 7, 2018.
- Meesters, M.E. & Behagel, J.H. (The Social Licence to Operate: Ambiguities and the neutralization of harm in Mongolia. *Resources Policy* 53, 274 282.

- Knotterus, Roeline and Cecilia Olivet 2016 Mongolia's experience with investment treaties and arbitration cases. TNI: Amsterdam.
- Lander, J. (2013) A critical reflection on Oyu Tolgoi and the Risk of a Resource Trap in Mongolia: Troubling the "Resource Nationalism" Frame. *Law, Social Justice and Global development Journal*. Available at https://warwick.ac.uk/fac/soc/law/elj/lgd/2013_2/2013_2_lander/. Accessed August 7, 2018.
- Langfitt, F. (2012) 'Mineral-Rich Mongolia Rapidly Becoming Mine-golia', *National Public Radio*. <http://www.npr.org/2012/05/21/152683549/mineral-rich-mongolia-rapidly-becoming-minegolia>. Accessed August 7, 2018.
- Li, Gupta, and Yu (2015) From Natural Resource Boom to Sustainable Economic Growth: Lessons for Mongolia, IMF Working paper 15 (90).
- Lyrودي, K. et al, 2004, Foreign Direct Investment And Economic Growth In Transition Economies, *South-Eastern Europe Journal of Economics*, 2004, (2) 1, 97-110.
- Meesters, M.E. and J.H. Behagel (2017). The Social License to Operate: Ambiguities and the Neutralisation of harm in Mongolia. *Resources Policy* 53: 274-282.
- Mineral Resources Authority of Mongolia <https://cmcs.mrpam.gov.mn/>. Accessed August 7, 2018
- Myadar, O. and S. Jackson (2019) Contradictions of Populism and Resource Extraction: Examining the Intersection of Resource Nationalism and Accumulation by Dispossession in Mongolia. *Annals of the American Association of Geographers* 109(2): 361-370, <https://doi.org/10.1080/24694452.2018.1500233>. Accessed August 7, 2018
- Rossabi, M. (2005) *Modern Mongolia: From Khans to Commissars to Capitalists*. Berkeley: University of California Press.
- Rossabi, M. (2013) Meteoric Mongolia: Why It's Ascending So fast – And How It Might Fall. *Foreign affairs*. <https://www.foreignaffairs.com/articles/mongolia/2013-01-29/meteoric-mongolia>, accessed 07 December 2018.
- Rosser, A. 2006, Escaping the Resource Curse, *New Political Economy*, (11) 4: 557-570.
- Salim, Emil, 2003, *Extractive Industries Review: Striking a better Balance*, Vol 1, The World Bank and the Extractive Industries. World Bank. Available at: <http://documents.worldbank.org/curated/en/222871468331889018/pdf/842860v10WP0St00Box382152B00PUBLIC0.pdf>. Accessed August 7, 2018.
- Shagdar, Engkhbayar (2007) Neo-Liberal "Shock Therapy" Policy During The Mongolian Economic Transition. *Economic Research Institute For Northeast Asia (ERINA)*. <https://www.erina.or.jp/en/wp-content/uploads/2018/05/DP0703e.pdf>. Accessed August 7, 2018
- USGS (United States Geological Survey) (1999) 'The mineral industry of Mongolia', U.S. Geological Survey – *Minerals Yearbook*. <http://minerals.usgs.gov/minerals/pubs/country/1999/9319099.pdf>, accessed 5 December 2016.
- World Bank. 1994. *Mongolia – Country economic memorandum: priorities in macroeconomic management (English)*. Washington, DC: World Bank, <http://documents.worldbank.org/curated/en/130331468757823098/Mongolia-Country-economic-memorandum-priorities-in-macroeconomic-management>, accessed August 7, 2018.

